МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА, ХӨГЖЛИЙН
ХҮРЭЭЛЭН

ТӨСВИЙН ХЯНАЛТЫН ТАЛААРХ ЭЗХАХБ БОЛОН ШИНЭ ЗЕЛАНД, СЛОВЕНИ, АРМЕНИ ЗЭРЭГ ОРНУУДЫН ТУРШЛАГА

Харьцуулсан судалгаа
Судалгааны код: **СТ-24/217**

ЗАХИАЛАГЧ:	УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Ж.БАЯРМАА
Хянасан:	ПСХХ-ийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга Д.Онолт
Судалгаа удирдсан:	ПСХХ-ийн хэлтсийн дарга П.Түмэнцэцэг
Судлаачид:	И.Жаргалзаяабямба Р.Нургүл

Улаанбаатар хот
2024

ГАРЧИГ

Хүснэгтийн жагсаалт 3
Графикийн жагсаалт 3
Зургийн жагсаалт 3
Товчилсон үгийн жагсаалт 4
УДИРТГАЛ 5
СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ 6
СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ 12
Нэг. ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ТУРШЛАГА, ЗӨВЛӨМЖ 12
Хоёр. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ ХЯНАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД 24
Гурав.ГАДААДЫН БУСАД ОРНЫ ТУРШЛАГА 30
3.1 ШИНЭ ЗЕЛАНД УЛС 30
3.2 БҮГД НАЙРАМДАХ СЛОВЕНИ УЛС 37
3.3 БҮГД НАЙРАМДАХ АРМЕНИ УЛС 42
Ашигласан эх сурвалж 46

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.Судлагдсан орнуудын төсвийн хяналттай холбоотой асуудлын харьцуулалт 8
Хүснэгт 2.ОУ-ын Төсвийн Түншлэлээс 2023 оны байдлаар судлагдсан орнуудын харьцуулалт 9
Хүснэгт 3.Олон Улсын Төсвийн Түншлэлийн байгууллагаас 2023 онд судлагдсан орнуудын хувьд төсвийн хяналтыг үнэлсэн оноо, зөвлөмж..... 10
Хүснэгт 4.ОУПХ, НҮБХХ-ийн тайланд төсвийн хяналтыг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүд..... 12
Хүснэгт 5.Парламентын төсвийн өмнөх хэлэлцүүлгийг хийдэг эсэх 14
Хүснэгт 6.Парламент дунд хугацааны төсвийн хүрээг хэлэлцэн баталдаг эсэх ... 18
Хүснэгт 7.Парламент төсвийн хэлэлцүүлэгт урт хугацааны тогтвортой байдалд дүн шинжилгээг хүлээн авч хэлэлцдэг эсэх 19
Хүснэгт 8.Төсвийн төслийг боловсруулах, батлах үйл явц..... 31
Хүснэгт 9.Санхүүгийн хоригийн сертификат хүргүүлэх хугацаа 33
Хүснэгт 10.Төсвийн гүйцэтгэлийн хяналтын төрөл..... 35

Графикийн жагсаалт

График 1. Парламент дунд хугацааны төсвийн хүрээг хэлэлцдэг эсэх (хувиар..... 17
График 2. Парламент урт хугацааны тогтвортой байдлын дүн шинжилгээг хүлээн авдаг эсэх..... 18
График 3.Парламентад өргөн мэдүүлдэг төсвийн тодотгол, тайлангууд..... 21

Зургийн жагсаалт

Зураг 1.Төсвийн хяналтын үйл явц дахь үе шатууд..... 16
Зураг 2.Төсвийг төлөвлөх, боловсруулах, хэлэлцэж батлах үе шат..... 30
Зураг 3.Төсвийн төслийн хэлэлцүүлэг 31
Зураг 4.Төсвийн гүйцэтгэл, хяналтын тайлан..... 34
Зураг 5.Төрийн санхүүгийн тухай хуульд заасан төсвийг боловсруулах явц..... 39
Зураг 6.Улсын төсвийн төслийг Парламентаар хэлэлцэн батлах үе шат..... 39

Товчилсон үгийн жагсаалт

ОУПХ	Олон Улсын Парламентын Холбоо
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ЭЗХАХБ	Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Хөгжлийн байгууллага
ТХЗ	Тогтвортой Хөгжлийн Зорилт
ҮСХ	Үндэсний Статистикийн Хороо
ТША	Төсвийн Шинжилгээний Алба
ЕХ	Европын Холбоо
АНУ	Америкийн Нэгдсэн Улс
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
ИБУИНХУ	Их Британи Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
CFISnet	Crown Financial Information System (Төрийн санхүүгийн мэдээллийн систем)
ТТБЗ	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл
ОУВС	Олон Улсын валютын сан
УИХ	Улсын Их Хурал
ТХББ	Төсвийн хараат бус байгууллага
ТББХ	Төрийн байгуулалтын байнгын хороо
ОУБ	Олон Улсын Байгууллага

УДИРТГАЛ

Улсын Их Хурлын гишүүн Ж.Баярмаагаас ирүүлсэн захиалгын дагуу “Төсвийн хяналтын талаарх ЭЗХАХБ болон Шинэ Зеланд, Словени, Армени Улсуудын туршлага” сэдэвт судалгааны ажлыг Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд гүйцэтгэв.

Судалгааны зорилго: **“**Төсвийн хяналтын талаарх ЭЗХАХБ болон Шинэ Зеланд, Словени, Армени Улсын туршлага” сэдвээр холбогдох харилцааг зохицуулж буй эрх зүйн орчныг харьцуулан судлах.

Судалгааны хамрах хүрээ: Судалгаанд ОУПХ болон НҮБХХ хамтарсан судалгааны тайлан, зөвлөмжүүд, ЭЗХАХБ болон ОУПХ, НҮБХХ, ЕХ, ОУТТ, ОУВС, Дэлхийн банк зэрэг байгууллагуудын олон улсын нийтлэг туршлагууд, Монгол Улсын эрх зүйн орчин, гадаадын Шинэ Зеланд, Словени, Армени Улсуудын төсвийн төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, хууль эрх зүйн орчин зэрэг асуудлын хүрээнд мэдээллийг харьцуулан судалсан болно.

Судалгааны ажлын бүтэц: Судалгаанд *Нэгдүгээрт*, төсвийн хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой ЭЗХАХБ болон бусад олон улсын байгууллагуудын нийтлэг туршлага, зөвлөмжүүд, *Хоёрдугаат,* Монгол Улсын төсвийн хяналттай холбоотой хууль тогтоомжууд, *Гуравдугаарт*, Шинэ Зеланд, Словени, Армени зэрэг орнуудын төсвийн хяналтыг хэрэгжүүлж буй туршлагыг судалгааны сэдвийн хүрээнд дэлгэрүүлэн судалсан болно.

Судалгааны арга зүй: Судалгааг холбогдох эрх зүйн зохицуулалт болон мэдээллийг гадаад хэлнээс хөрвүүлэх, судалгааны захиалга болон удирдамжид заасан чиглэлийн дагуу мэдээллийг харьцуулан судлах, нэгтгэн дүгнэх арга зүйг ашиглан гүйцэтгэв.

***Keywords*:** *Budgetary control*

***Түлхүүр үг:** Төсвийн хяналт*

СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

ОУПХ, НҮБХХ-ийн хамтарсан “Дэлхийн парламентын хяналт” тайланд[1] дэлхийн 100 парламентын төсвийн хяналтыг хэрэгжүүлэх, төсвийн дүн шинжилгээ хийх чадавхыг сайжруулах, мэдээлэл цуглуулах, дата сан бүрдүүлэх, төсвийн шинжилгээний албаар дамжуулан хэрэгжүүлэх, жендерийн мэдрэмжтэй төсөв батлах тухай асуудлуудыг зөвлөмжид тусгажээ.

Дээрх тайланд дурдсанаар, дэлхийн хэмжээнд төсвийн хяналтыг дараах арга механизмуудыг ашиглан хэрэгжүүлж, парламентын хяналтын үүргийн бэхжүүлэх, үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилготой. Үүнд:

- Төсвийн төслийг боловсруулахаас өмнө Парламент дээр төсвийн тэргүүлэх чиглэлийг хэлэлцдэг -нийт улс орны 40%;
- Төсвийн төсвийг Парламентаар хэлэлцэн батлахаас дор хаяж 3 сарын өмнө хүлээж авдаг- нийт улс орны 30%;
- Төсвийн төслийг 1 ба түүнээс олон хороогоор нягтлан шалгадаг -нийт улс орны 0%;
- Төсвийн төсөлд жендерийн нөлөөллийн анализ хийдэг-нийт улс орны 20%;
- Парламент өөрөө төсвийн төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй-нийт улс орны 40%;
- Төсвийн жилийн туршид Парламентад төсвийн орлого, зарлагын талаарх мэдээллийг тодорхой хугацааны үечлэлээр тогтмол ирүүлдэг -нийт улс орны 50%;
- Үндэсний аудитын байгууллагаас Парламентад төсвийн талаарх тайлан ирүүлдэг- нийт улс орны 90%;
- Парламентаар нарийвчлан хэлэлцэх тодорхой журам тогтоодог -нийт улс орны 60%;
- Төсвийн дүн шинжилгээ хийх чадавхтай дотоод бүтцийн нэгжтэй байх- нийт улс орны 60%.

Сүүлийн үед дэлхийн улс орнуудын парламентууд төсөв хэлэлцэн батлах, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, хэрэгжүүлэх бүрэн эрх, чадавхыг сайжруулахад ихээхэн анхаарч байна. ЕХ-ны гишүүн орнуудын “Төсвийн хяналт шалгалт хийхэд парламентын үүрэг оролцоо” сэдэвт хамтарсан тайланд дараах асуудлуудыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгсөн байна. Үүнд:[2]

- Парламентын санхүүгийн хяналтыг цаашид хөгжүүлэх талаар төсөөлөлтэй байх;
- Төсвийн зарлагын асуудлаар гишүүдэд төсвийн өмнө хэлэлцүүлэг явуулах;
- Татвар, төсвийн зарцуулалтын нарийвчилсан төлөвлөгөөг төрийн бодлоготой уялдуулан танилцуулах;

[1] *Global Parliamentary Report, 2017*https://www.undp.org/publications/global-parliamentary-report-2017

[2] *The role of the Parliament in the Budget scrutiny process, 2019* https://www.sobranie.mk/content/%D0%9F%D0%B0%D1%80%D0%BB%D0%B0%D0%BC%D0%B5%D0%BD%D1%82%D0%B0%D1%80%D0%B5%D0%BD%20%D0%B8%D0%BD%D1%81%D1%82%D0%B8%D1%82%D1%83%D1%82/Billateral%20research%20Macedonia%20and%20Czechia%2012,19.pdf

- Санхүүгийн хороодын чиг үүргийг бэхжүүлэх, төсвийн үйл явцад голлох байр суурь эзлэх;
- Парламентын хороодын төсвийн тухай хуулийг хэлэлцэх чадамжаа нэмэгдүүлэх;
- Парламентаас зарцуулалтыг батлах хөтөлбөрүүдийн санхүүгийн зардлыг хавсаргах;
- Засгийн газраас төсвийн жилд дэвшүүлсэн гүйцэтгэлийн зорилтыг хавсаргах;
- Төсвийн хороод болон алба, нэгжүүд бие даасан, эрх мэдэлтэй, хараат бус байх, парламентын мэргэжилтнүүд төсвийн талаарх эдийн засгийн тооцоо, шинжилгээг хавсаргах;
- Парламент нь төсөв боловсруулах үйл явцад жендерийн оролцоог нэмэгдүүлэх хувилбарыг судалж, жендерийн нөлөөллийн үнэлгээг үндэслэнэ.

Засгийн газраас өргөн барьсан төсвийн төсөлд өөрчлөлт оруулах, төсвийг хянах эрх бүхий байгууллагыг хараат бус байлгах, хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлд нийцүүлэн төсвийн төсөлд судалгаа, тооцоо, шинжилгээ хийх, төсвийн хэлэлцүүлэгт бэлтгэх, төсөв батлагдсаны дараах хяналтыг хэрэгжүүлэх зэрэг үйл ажиллагааг парламентын болон бусад ажлын албаны тодорхой бүтцийн нэгжүүдээр дамжуулан хэрэгжүүлдэг байна.

ЭЗХАХБ-ын мэргэжилтнүүдийн судалснаар, гишүүн орнуудын хувьд төсвийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлсийг гаргасан байна. Энэ эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлд төсөв болон макро эдийн засгийн төсөөллийн алдаа, төсвийн хэврэг байдал (*тухайлбал, газрын тосны үнэ, сангийн бодлогын алдаа, хөрөнгийн зах зээлийн хөөсрөлт, тэтгэврийн сан, төр хувийн хэвшлийн эрсдэл, банк санхүүгийн салбарын эрсдэл, гэрээгээр хүлээсэн үүрэг, гаргасан баталгаанууд, байгалийн гамшиг*) зэрэг хүчин зүйлс нөлөөлдөг байна. Эдгээр эрсдэлээс хамгаалахын тулд хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй төсвийн үйл явц, төсвийн эрсдэлийн удирдлагад хяналт тавих чиг үүрэг бүхий Төсвийн зөвлөлийг (Budget Council) сүүлийн үед 50 гаруй улс орнууд байгуулжээ. (*хавсралт харна уу)*

Монгол Улсын хувьд Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийг 2017 онд байгуулсан бөгөөд 2024 оноос эхлэн байнгын ажиллагаатай болсон байна. Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн тухай хуулийн 16[1].1 дэх зүйлд “Улсын Их Хурлаас Монгол Улсын нэгдсэн төсвийн тогтвортой байдлыг хангуулах үүрэг бүхий хараат бус, бие даасан, **байнгын ажиллагаатай** Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-ийг байгуулна” гэж тусгажээ. ТТБЗ нь Засгийн газраас гаргасан албан ёсны макро эдийн засаг болон төсвийн төсөөллийн үнэлгээг хийх чиг үүрэгтэй. Энэ зөвлөл нь орон тооны 7 гишүүдээс бүрдэх бөгөөд Төсвийн Байнгын Хорооны нэр дэвшигчийг нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгаруулж, УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсголыг зохион байгуулдаг байна.

Дээрх тайлан, судалгаанаас харахад төсвийн хяналтыг хэрэгжүүлэхэд парламентын болон хороод, төсвийн зөвлөл, бусад алба, нэгжийн оролцоог чухалчилдаг бөгөөд улс орон бүр харилцан адилгүй байна.

Судалгаанд Монгол Улс, Шинэ Зеланд, Словени, Армени зэрэг орнуудыг сонгон авч төсвийн хяналтын эрх зүйн орчин, төсвийн үйл явц, төсвийн гүйцэтгэлийн хяналтын талаар дэлгэрүүлэн судалсан болно.

Хүснэгт 1.Судлагдсан орнуудын төсвийн хяналттай холбоотой асуудлын харьцуулалт

Улсын нэр	Монгол Улс	Шинэ Зеланд	Словени Улс	Армени Улс
Хууль эрх зүй	• Үндсэн хууль; • УИХ-ын тухай хууль; • УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль; • УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль; • Төрийн аудитын тухай хууль;	• Төрийн санхүүгийн хууль; • Парламентын дэгийн тухай хууль; • Төрийн аудитын тухай хууль;	• Төрийн санхүүгийн тухай хууль; • Стратегийн хөгжлийн баримт бичиг, улсын төсвийн төслийг боловсруулах үндэслэл, журмын тухай тогтоол; • Парламентын дэгийн тухай хууль.	• Улсын төсвийн тогтолцооны тухай хууль; • Үндэсний Ассамблейн дэгийн тухай хууль; • Төрийн сангийн тогтолцооны тухай хууль.
Парламентын төсвийн хяналт	• төсвийн төслийн боловсруулалтын үе шатанд тавих хяналт; • Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатанд тавих хяналт; • Төсвийн хэрэгжилтэд тавих хяналт.	Парламент нь төсвийг баталж, хяналт тавьдаг.	Төсвийн гүйцэтгэлд хяналт тавихыг Сангийн яам хэрэгжүүлнэ.	Улсын төсвийн гүйцэтгэл, гадаад улс орон, ОУ-ын байгууллагаас авсан зээл, зарцуулалтад Парламент хяналт тавина[3]. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн гүйцэтгэлийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэнэ.
Парламентын төсвийн хороо болон алба, нэгж	• Төсвийн байнгын хороо;	Санхүүгийн зарлагын Байнгын хороо;	-Санхүүгийн Байнгын хороо; -Төрийн санхүүгийн хяналтын хороо;	- Зөвлөл[4]; -Байнгын хороо; -Төсвийн алба;
Төсвийн бие даасан байгууллага (Independent fiscal institution IFI)	Төсвийн тогтвортой байдлын зөвлөл нь бие даасан байгууллага юм. Парламентад ажлаа тайлагнадаг.	Төсвийн даасан санхүүгийн байгууллага байдаггүй.[5]	Төсвийн зөвлөл нь төсвийн бие даасан байгууллага бөгөөд Парламент ба ЗГ ажлаа тайлагнадаг.	Төсвийн даасан санхүүгийн байгууллага байдаггүй[6]
Төсвийн гүйцэтгэлийн хяналтын үе шат	• I хэлэлцүүлгийн үе шатны хяналт; • II хэлэлцүүлгийн үе шатны хяналт.	• I хэлэлцүүлэгт, төсвийн төсөл танилцуулна; • II хэлэлцүүлэгт, Байнгын хороо хэлэлцэж, санал авч, Парламентад танилцуулна; • III хэлэлцүүлэгт, төсвийн төслийг парламентаар хэлэлцүүлж, батална	• I хэлэлцүүлэгт, төсвийн өргөн мэдүүлснээс хойш 10 хоногийн дараа танилцуулна. • II хэлэлцүүлэгт, Байнгын хороо, парламентын нэгжүүд төсвийн төслийг 15 хоногийн дараа хэлэлцэж, нэмэлт өөрчлөлт оруулах санал авч хэлэлцэнэ. • III хэлэлцүүлэгт, Засгийн газрын	• I хэлэлцүүлэгт, төсвийн төслийг өргөн мэдүүлснээс 2 өдрийн дотор Ерөнхий сайд зөвшилцөн урьдчилсан хэлэлцүүлэг хийх, Байнгын хороо оруулж, өргөн мэдүүлнэ. • II хэлэлцүүлэгт, анхны хэлэлцүүлгээр батлагдсан хуулийн төсөлд санал оруулна. Хэлэлцүүлэг явуулах

[3] *Армени Улсын Парламентын дэгийн тухай хуулийн 5 бүлэг, 24-2*
[4] *Зөвлөлд Парламентын дарга, түүний 3 орлогч дарга, бүлгийн 1 төлөөлөгч, БХ даргаас бүрдэнэ.*
[5] *Шинэ Зеландын төсвийн хяналт* *https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/new-zealand*
[6] *Армени Улсын төсвийн хяналт* *https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/armenia*

			төсвийг боловсруулснаас 30 хоногийн дараа хуулийн төслийн санал авч, хэлэлцүүлж батална.	ахлах Хороо танилцуулна. Хэрэв төрийн нууцад хамаарах улсын төсвийн гүйцэтгэлийн тайлан БХ хаалттай хуралдаанаар хэлэлцэж батална.

(Дэлгэрэнгүйг судалгаанаас харна уу)

Олон Улсын Төсвийн Түншлэл (*International Budget Parthership*)-ийн 2023 оны “Төсвийн нээлттэй судалгаа“ сэдэвт тайланд дэлхийн 125 улс орнуудыг хамруулан улсын төсвийн хяналт, төсвийн ил тод байдал, төсөвт олон нийтийн оролцоог хангах зэрэг зарчмуудыг оролцуулан 0-100 хүртэл онооны шалгуур үзүүлэлтээр харьцуулан үнэлсэн байна. Энэ үнэлгээгээр судалгаанд авагдсан 4 орны оноогоор дараах байдлаар авч үзсэн байна.

Хүснэгт 2.ОУ-ын Төсвийн Түншлэлээс 2023 оны байдлаар судлагдсан орнуудын онооны харьцуулалт

(100 онооноос)

Улс орнууд	Төсвийн хяналт	Төсвийн ил тод байдал	Төсөвт олон нийтийн оролцоог хангах
Монгол Улс	80	62	19
Шинэ Зеланд Улс	78	87	55
Словени Улс	78	64	9
Армени Улс	59	60	11

Дээрх тайланд дурдсанаар улс орнуудын төсвийн хяналтын харьцуулалтыг авч үзвэл:

- **Монгол Улсын хувьд**: парламент төсвийн төлөвлөлтийн үе шатанд хангалттай сайн хяналт тавьдаг бөгөөд төсвийн хэрэгжилтийн шатанд хязгаарлагдмал хяналт тавьдаг байна[7].
- **Шинэ Зеланд Улсын хувьд**: эсрэгээр парламент төсвийн төлөвлөлтийн үе шатанд хязгаарлагдмал хяналт тавьдаг бөгөөд хэрэгжилтийн үе шатанд хангалттай сайн гэж дүгнэсэн байна[8].
- **Словени Улсын хувьд**: парламент нь төсвийн төлөвлөлт болон хэрэгжилтийн үе шатанд аль алинд нь хангалттай сайн хяналт тавьдаг байна[9].
- **Армени Улсын хувьд**: парламент болон аудитын байгууллага нь төсвийн үйл явц, хяналт хэрэгжүүлэхэд хязгаарлагдмал хяналт тавьдаг бөгөөд төсвийн төлөвлөлтийн үе шатанд тавих хяналт сайн, харин гүйцэтгэлийн шатанд сул хяналт тавьсан[10] гэж Олон Улсын Төсвийн Түншлэлээс 2023 оны байдлаар “Төсвийн нээлттэй судалгаа“ тайланд дурдсан байна.

[7] *Монгол Улсын төсвийн хяналт* *https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/mongolia*
[8] *Шинэ Зеландын төсвийн хяналт* *https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/new-zealand*
[9] *Словени Улсын төсвийн хяналт* *https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/slovenia*
[10] *Армени Улсын төсвийн хяналт* *https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/armenia*

Хүснэгт 3.Олон Улсын Төсвийн Түншлэлийн 2023 онд судлагдсан орнуудын хувьд төсвийн хяналтыг үнэлсэн оноо, зөвлөмжүүд

(оноогоор)

Улс орнууд	Төсөвт тавих хяналтыг доорх байдлаар 2 төрөлд ангилна.		Төсвийн хяналтыг сайжруулах чиглэлээр өгсөн зөвлөмжүүд
	Парламентын хяналт	Аудитын хяналт	
Монгол Улс (төсвийн хяналт 80 оноотой)	75	89	- УИХ-ын Төсвийн байнгын хороо нь тухайн жилийн төсвийн гүйцэтгэлийг шалгаж, дүгнэлтийг цахим системд ил нийтлэх; - ЗГ-ын батлагдсан төсөвт хөрөнгийг тухайн төсвийн жилийн хугацаанд засаг захиргааны нэгжид шилжүүлэхийн өмнө УИХ-тай зөвшилцсөн байхаар[11] зөвлөмж өгсөн.
Шинэ Зеланд (төсвийн хяналт 78 оноотой)	72	89	- ЗГ төсвийн төслийг эхлэхээс хоёр сарын өмнө Парламентад өргөн мэдүүлэх[12]; - Парламент болон олон нийт төсвийн мэдээлэл, төсвийн зардлын талаар зөвлөгөө авах; - Аудитын Ерөнхий газрын үйл ажиллагааг хараат бус байдлыг бэхжүүлэх, хяналтыг сайжруулахын тулд аудитын үйл ажиллагааг хараат бус байгууллагаар хянуулах зөвлөмж өгсөн.
Словени Улс (төсвийн хяналт 78 оноотой)	75	83	- ЗГ төсвийн төслийг өргөн барихаас өмнө Парламентын төсвийн бодлогыг хэлэлцэх, ирэх оны төсөвтэй холбоотой зөвлөмжийг батлах;[13] - БХ, Аудитын тайланг шалгаж, дүгнэлтээ цахим системд ил нийтлэх; - Аудитын шүүхийн хараат бус байдлыг бэхжүүлэх, хяналтыг сайжруулахын тулд аудитын үйл ажиллагааг хараат бус байгууллагаар хянуулах зөвлөмж өгсөн.
Армени Улс (төсвийн хяналт 59 оноотой)	53	72	- БХ нь төсвийн төсөл, жилийн тайлан, аудитын тайлан хэлэлцээд дүгнэлтээ нийтлэх[14]; - Төсөвт заасан хөрөнгийг засаг захиргааны нэгжид шилжүүлэх, төлөвлөөгүй орлогыг зарцуулах, орлого тасалдсан улмаас зарлагыг бууруулахдаа парламент, хороод зөвшилцсөн байх; - Аудитын танхимын хараат бус байдлыг бэхжүүлэх, аудитын хяналтыг сайжруулахын тулд а) аудит чиг үүргээ хэрэгжүүлэх хангалттай төсөвтэй байх; б) аудитыг хараат бус байгууллагаар хянуулах зөвлөмж өгсөн байна.

Эх сурвалж: International Budget Partnership,2023

[11] *Монгол Улсын төсвийн хяналт* https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/mongolia

[12] *Шинэ Зеландын төсвийн хяналт* https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/new-zealand

[13] *Словени Улсын төсвийн хяналт* https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/slovenia

[14] *Армени Улсын төсвийн хяналт* https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/armenia

Судалгаанд авагдсан орнуудын хувьд, дээрх хүснэгтээс харахад төсөвт тавих аудитын хяналт нь парламентын хяналтаас харьцангуй өндөр байгаа нь аудитын байгууллагын ажилтнуудын чадавх (*шинжилгээ судалгаа, дүн шинжилгээ, бодлогын зөвлөмж боловсруулах, мэргэшсэн ажилтантай, хараат бус*) ур чадварын шалгуур үзүүлэлт өндөр, аудитын байгууллагын менежментийн тогтолцооны чанарын удирдлага сайтай, олон улсын аудитын стандартыг мөрдлөг болгодог, үйл ажиллагааны үр дүн, үр ашиг сайн байгаатай холбоотой байна.

ОУВС-гийн Монгол Улсыг хариуцсан ажлын хэсэг 2024 оны байдлаар Монгол Улсын төсвийн талаар зөвлөмж гаргасан байна. Үүнд: “Монгол Улсын гадаад секторын болон төсвийн нөөцийг нэмэгдүүлэх нь хөрөнгө оруулалт, бусад шинэчлэлийг эдийн засгийн шингээх чадвартай уялдуулан үр дүнтэй хэрэгжүүлэх, гадаад болон дотоод тэнцвэрт байдлыг хадгалах нөхцөлийн талаар судалсан байна. Энэ нөхцөлд төсвийн бодлогыг хумьж, төсвийн тусгай шаардлагыг дагаж мөрдөн, мөнгөний болон макро эдийн засгийн зохистой хатуу бодлого баримтлан, санхүүгийн салбар болон төсвийн хяналт шалгалтыг боловсронгуй болгох шаардлагатай байна” гэж зөвлөжээ[15].

[15] *МУ:ОУВС-гийн МУ-ыг хариуцсан мэргэжилтнүүдийн байр суурь (mongolia-mcs-2024-mon (2).pdf)*

СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ

Нэг. ОЛОН УЛСЫН НИЙТЛЭГ ТУРШЛАГА, ЗӨВЛӨМЖ

Олон Улсын Парламентын Холбоо (IPU) болон Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр (UNDP) хамтран дэлхийн 150 орны парламент ба парламентын гишүүдийг хамруулан парламентын хяналт шалгалтын эрх мэдэл, түүнийг практикт хэрэгжүүлж буй байдлын талаар өргөн хүрээтэй судалгаа явуулж, парламентаас хянан шалгах чиг үүргээ хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, парламентын хяналтыг үр ашигтай явуулахад шаардагдах нөхцөл, эрх зүйн орчин бүрдүүлэхэд анхаарах асуудлуудаар 6 бүлэг, 28 зүйл бүхий зөвлөмж гаргасан байна. Энэхүү зөвлөмжид парламентын хяналтын үр ашигтай зохицуулалтын механизмыг бүрдүүлэх хүрээнд төсвийн хяналтыг сайжруулахтай холбоотой асуудлуудыг доорх хүснэгтэд тусгажээ.

Хүснэгт 4.ОУПХ, НҮБХХ-ийн тайланд төсвийн хяналтыг сайжруулахтай холбоотой зөвлөмжүүд

Төсвийн хяналт (Oversight of the budge	Парламент нь төсвийн орлого бүрдүүлэлтээс гадна төрийн санхүү, төсвийн зарцуулалтыг хянах эрхтэй. Засгийн газраас парламентад төсвийн зарцуулалтын саналаа ирүүлэх болон Парламентаас Засгийн газар төсвийн орлогоо хэрхэн бүрдүүлж, хэрхэн зарцуулах гэж байгаа, төсөв зарцуулах тэргүүлэх салбар нь тодорхойлох, олон нийтийн эрэлт хэрэгцээнд энэ хуваарилалт нийцэж байгаа эсэхийг хянаж, төсвийг аль болох иж бүрэн, ил тод, үндэслэл тооцоотой байлгадаг байна.
	Парламентаас төсвийн хяналтын бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд Төсвийн шинжилгээ чухал. Энэхүү чадавхыг бүрдүүлснээр Парламентаас төсвийн хувилбаруудыг тооцоолох, Засгийн газраас хараат бусаар төсөв хэлэлцэх чадавх бүрддэг байна. Парламентын хувьд төрийн санхүүгийн менежмент, төсвийн циклийг хянах асуудал нь мөрдөн шалгах, судалгаа дүн шинжилгээ хийх ур чадварыг шаардах тул улс орнуудын Парламент янз бүрийн түвшинд олон асуудлуудтай тулгарсаар байна.
Төсвийн хяналтыг хэрэгжүүлэх боломжууд	Дэлхийн 100 парламентын танхимд төсвийн хяналтын дараах арга механизмуудыг ашиглан хэрэгжүүлдэг байна: • төсвийн төслийг боловсруулахаас өмнө Парламент дээр төсвийн тэргүүлэх чиглэлийг хэлэлцдэг 40%; • төсвийн төсвийг Парламентаар хэлэлцэн батлахаас дор хаяж 3 сарын өмнө хүлээж авдаг 30%; • төсвийн төслийг 1 ба түүнээс олон хороогоор нягтлан шалгадаг 80%; • төсвийн төсөлд жендерийн нөлөөллийн анализ хийдэг 20%; • Парламент өөрөө төсвийн төсөлд өөрчлөлт оруулах эрхтэй 40%; • төсвийн жилийн туршид Парламентад төсвийн орлого, зарлагын талаарх мэдээллийг тодорхой хугацааны үечлэлээр тогтмол ирүүлдэг 50%; • Үндэсний аудитын байгууллагаас Парламентад төсвийн талаарх тайлан ирүүлдэг 90%; • уг тайланг Парламентаар нарийвчлан хэлэлцэх тодорхой журам тогтоодог 60%; • төсвийн дүн шинжилгээ хийх чадавхтай дотоод бүтцийн нэгжтэй байх 60%.
Төсвийн дүн шинжилгээ хийх чадавх бүрдүүлэх	Төсвийн дүн шинжилгээ хийх нь мэргэшсэн ур чадвартай экспертийн ажил юм. Гишүүдийн хувьд төсвийн концепц болон арга зүйг ерөнхийд нь мэдэх шаардлагатай бол Парламентын ажлын албаны мэргэшсэн шинжээчид нарийвчилсан анализ хийх чадвартай байдаг. Бусад орнуудын туршлагаас үзвэл энэ чиглэлээр гишүүд болон ажилтнууд тусгайлсан сургалтад хамрагддаг байна.

Мэдээлэл цуглуулах, дата сан бүрдүүлэх	Төсвийн хяналт шинжилгээ хийхэд дата сан бүрдүүлэх нь асуудал чухал байдаг. Парламентаас ТХЗ-2030 зорилтуудыг хангах, хууль тогтоомж, бодлогын хэрэгжилтийг хянах, үнэлэх хүрээнд ҮСХ-той хамтран ажиллаж мэдээллийг, ямар аргачлалаар, ямар эх үүсвэрээс, хэрхэн бүрдүүлэх асуудлыг шийдвэрлэдэг байна.
Парламентын Төсвийн шинжилгээний алба	2008 оны дэлхийн санхүүгийн хямралаас хойш ихэнх Парламентууд дүн шинжилгээний чадавхаа бэхжүүлэхэд анхаарч Төсвийн шинжилгээний алба (ТША)-ыг дотоод бүтцэдээ байгуулж эхэлсэн, хөндлөнгийн ТША-ны үйлчилгээг ч авч эхэлсэн. ТША нь олон улсын болон үндэсний зохицуулалтад нийцүүлэн төсөвт мониторинг, дүн шинжилгээ хийх, төсвийн техникийн нарийн мэдээллүүдийг хялбаршуулан танилцуулах зэрэг үүргийг хүлээнэ. Италийн туршлагаас үзэхэд, ТША нь макро эдийн засгийн бодлого, төсвийн төслийн төсөөлөлд анализ хийх, төсвийн хэрэгжилтийг ЕХ болон үндэсний хууль тогтоомжуудад нийцүүлэн мониторинг хийх, Хороодын захиалгын дагуу төсөвтэй холбоотой судалгаа, дүн шинжилгээ хийх үүрэгтэй. Бусад орнуудын туршлагаас үзэхэд, хүчин чадал сайтай Парламентуудын ТША илүү мэргэшсэн, иж бүрэн төсвийн анализ хийх чадавхтай байгаа бол жижиг орнуудын хувьд санхүү, хүний нөөц хомс байх тул Үндэсний аудитын газрыг төсвийн шинжилгээний чиглэлээр Парламентад зөвлөх, хараат бус дүн шинжилгээ гаргаж өгөх хөндлөнгийн мэргэшсэн байгууллага гэж үздэг байна.
Жендерийн мэдрэмжтэй төсөв батлах	Ихэнх орнууд төсвийн төсөлд жендерийн мэдрэмжийн анализ хийдэг. Жендерийн төсөвлөлт, гүйцэтгэлийн үнэлгээг тайлагнасан улс орнууд нэмэгдсэн.

Эх сурвалж: УИХТГ-ын ПСХХ-ийн "Парламентын төсөв санхүүгийн хяналт, олон улсын туршлага" харьцуулсан судалгаа.

ЭЗХАХБ: Төсвийн үйл явц дахь парламентын оролцоо (Budgeting and Public Expenditures in OECD, 2019)

ЭЗХАХБ-ын Төсвийн засаглалын талаарх зөвлөмжид тусгаснаар Засгийн газрууд нь Парламент болон түүний холбогдох хороодтой төсвийн мөчлөгийн бүхий л үе шат (үүнд урьдчилсан/ex ante болон гүйцэтгэлийн/ex post)-д төсвийн үйл явцтай холбоотой асуудлаар хамтран ажиллаж, төсвийн төслийн талаар хүртээмжтэй, оролцоотой, бодитой мэтгэлцээн өрнүүлэх боломж бүрдүүлдэг гэж ЭЗХАХБ-ын зөвлөмжид дурджээ.

ЭЗХАХБ-ын гишүүн улс орнуудын[16] парламентууд өөр өөрийн хууль эрх зүйн орчны онцлог, процедур, ёс заншил, уламжлалд захирагддаг боловч ихэнх орон нь "төсөвт нөлөөлөх" чадвартай буюу гүйцэтгэх засаглалаас өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах, буцаах эрх зүйн чадамжтай байна.

Төсвийг батлах үе шатууд нь ихэнх парламентын хувьд төсвийн оролцооны гол үе шат бөгөөд парламентын зүгээс төсвийн жилийн турш тасралтгүй санхүүгийн хяналт тавих асуудал юм. Парламент нь төсвийн хяналтад Үндсэн хууль дахь төрийн эрх мэдлийн хуваарилалт, улс төрийн нам болон сонгуулийн тогтолцоо, Засгийн газрыг бүрдүүлдэг уламжлал практик (*олонхын Засгийн газар уу, эсхүл эвслийн*

[16] *ЭЗХАХБ-ын 38 гишүүн орон: Австри, Австрали, Бельги, Канад, Чили, Колумб, Коста Рика, Чех, Дани, Эстони, Финланд, Франц, Герман, Грек, Унгар, Исланд, Ирланд, Израиль, Итали, Япон, Солонгос, Латви, Литва, Люксембург, Мексик, Нидерланд, Шинэ Зеланд, Норвеги, Польш, Португал, Словак, Словени, Испани, Швед, Швейцарь, Турк, Их Британи, АНУ*

Засгийн газар уу) болон төсвийн дүрмийн хязгаарлалт, төсвийн орчин зэрэг хүчин зүйлүүд нөлөөлдөг байна.

Төсвийн өмнөх хэлэлцүүлэг

ЭЗХАХБ-ын тайлангаас үзэхэд, гишүүн орнуудын парламентууд Засгийн газраас жилийн төсвийн төслийг өргөн мэдүүлэхээс өмнөх үе шатанд төсвийн бодлогын чиглэл, тэргүүлэх чиглэл, харилцан тохиролцооны асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлдэг хандлага байна.

Засгийн газраас төсвийн жилийн төлөвлөгөө (pre-budget debate)-г боловсруулан Парламентад өргөн мэдүүлдэг улс орнуудын тоонд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байгаа ч парламент нь төсвийн өмнөх хэлэлцүүлэг хийдэг улс орнуудын тоо нэмэгдсэн байна. Эдгээр парламентуудын 50 орчим хувь нь төсвийн өмнөх хэлэлцүүлгийн үр дүнг Засгийн газарт тайлан болгон илгээдэг байна. Үүний нэг жишээ **Швед Улсын** Риксдаг нь хоёр шатлал бүхий хууль тогтоох процесстой бөгөөд Засгийн газраас хавар 04 дүгээр сард өргөн мэдүүлдэг Төсвийн бодлогын тухай (Spring Fiscal Policy Bill) хуулийн төсөл (төсвийн хүрээний мэдэгдэл) нь төсвийн бодлогын талаар илүү ерөнхий хэлэлцүүлэг хийх боломжийг олгодог бол 09 дүгээр сард өргөн мэдүүлдэг төсвийн төсөлд Засгийн газрын дараа жилийн төсвийн зардлын нарийвчилсан саналуудыг тусгадаг байна[17].

Судалгаанд авагдсан хэд хэдэн парламентууд чуулганы нэгдсэн хуралдаанаар албан ёсны хэлэлцүүлэг хийдэггүй ч Төсвийн хороо нь төсвийн өмнөх үе шатанд оролцож хэлэлцүүлэг хийдэг талаар мэдээлсэн байна. Бүгд Найрамдах Чех Улсад Төсвийн хороо нь төсвийн өмнөх хэлэлцүүлэг хийж, төсвийн стратеги, нэгдмэл байдлыг хангах талаар тогтоол баталдаг байна. Ирланд Улсад шинээр байгуулагдсан Төсвийн хяналтын хороо нь төсвийн тэргүүлэх чиглэлийн талаар төсвийн урьдчилсан сонсгол хийж, тайланг нэгдсэн хуралдаанд танилцуулдаг байна. Израил Улсад Санхүүгийн хороо нь заримдаа төсвийн төслийг боловсруулах явцад өөрсдийн сонирхлоо илэрхийлэх зорилгоор төсвийн өмнөх хэлэлцүүлгийг зохион байгуулсан байдаг байна.

Хүснэгт 5.Парламентын төсвийн өмнөх хэлэлцүүлгийг хийдэг эсэх

Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулдаг эсэх	Улсын тоо	Улсын тоо
Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулж, тайланг Засгийн газарт хүргүүлдэг	6	Канад, Франц, Грек, Итали, Словени, Швед
Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулдаг боловч тайлан гаргадаггүй	7	Дани, Испани, Нидерланд, Португал, Швейцар, Шинэ Зеланд, Эстони

[17] *Budgeting and Public Expenditures in OECD Countries 2019. page 82* https://www.oecd-ilibrary.org/docserver/9789264307957-en.pdf?expires=1730710839&id=id&accname=guest&checksum=8043FBB98CEADF7109DDB4EB08912D86

Төсвийн өмнөх хэлэлцүүлэг явуулдаггүй	17	АНУ, Австри, Австрали, Бельги, БНСУ, Исланд, ИБУИНХУ, Норвег, Латви, Люскембург, Словак, Турк, Унгар, Польш, ХБНГУ, Чили, Япон
Бусад	4	Ирланд, Израил, Финланд, Чех
Нийт	**34**	

Эх сурвалж: https://www.oecd.org/gov/budgeting/Parliament-role-in-budgeting.pdf

Төсвийн хяналтын зорилтууд
(Objectives of Budgetary Control)[18]

- **Төсвийн төсөөлөл** (Plan for the Future)**:** Төсвийн хяналт нь төсвийн төсөөллөөр төсвийн орлого, зарлагыг урьдчилан таамаглан төлөвлөж, стратеги төлөвлөгөөгөө боловсруулдаг байна.
- **Үйл ажиллагааг зохицуулах** (Coordinate Activities): Төсвийн хяналт нь байгууллагын газар, хэлтэс, нэгжүүдийн үйл ажиллагааг зохион байгуулах, төсвийн хөрөнгийг давхардуулахгүйгээр зохицуулна.
- **Зардлыг хянах** (Control Costs)**:** Тухайн байгууллагуудад төсөв зарцуулалтыг тогтоож, төлөвлөсөн зорилтуудын бодит төсвийн гүйцэтгэл болон зардлыг хянах, хэтрүүлсэн зардлыг бууруулах арга хэмжээ авдаг байна.
- **Үр ашгийг сайжруулах** (Improve Efficiency): байгууллагуудад төсвийн хөрөнгийг үр ашгийг сайжруулахын тулд төсвийн хөрөнгийг хэмнэх талаар үйл ажиллагааны дүрэм журамд нэмэлт, өөрчлөлтийг оруулдаг байна.
- **Ашгийг нэмэгдүүлэх** (Increase Profitability)**:** Төсвийн хяналт нь байгууллагуудад төсвийн хөрөнгийг үр ашигтай, үр дүнтэй ашиглах, ашиг орлогоо нэмэгдүүлэхийн тулд орлого нэмэгдүүлж, зардлыг бууруулах замаар ашгийг нэмэгдүүлдэг байна.

Төсвийн хяналтын нийтлэг зарчим
(Common Principles of Budgetary control)[19]

- **Төсөв бодит байх** (Set realistic budgets): өмнөх жилүүдийн төсөв, үнэн зөв мэдээллийг эсхүл харьцуулж болохуйц мэдээлэлд тулгуурлан төсвийг бодитоор төсөвлөсөн байх;
- **Уян хатан байх** (Be flexible): зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан тохируулга хийж болохуйц болон дасан зохицох байдлыг үндэслэн төсвийг уян хатан байлгах;
- **Харилцан ойлголцох** (Communicate): төсвийн хяналт хийх ажилтнуудын хоорондын харилцан ойлголцох, хамтын ажиллагаанд тулгуурлах;
- **Хянах үйл явц (**Monitor progress): аливаа төсөвтэй холбоотой асуудлыг эрт илрүүлэхийн тулд төсөвт тогтмол хяналт тавих;
- **Засах арга хэмжээ** (Take corrective action): төсвийн зарцуулалтыг хянах, гарсан зөрүүг нэн даруй засах арга хэмжээ авах.

[18] *Objectives of Budgetary Control* https://www.shiksha.com/online-courses/articles/budgetary-control-steps-objectives-and-advantages/
[19] *Common principles of budgetary control* https://online.sunderland.ac.uk/what-is-budget-control/

Төсвийн хяналтын үйл явц дахь үе шатууд[20]
(Steps in the Budgetary Control Process)

1. **Санхүүгийн зорилтууд** (Set Financial Objectives): Төсвийн хяналтын үйл явцад орлого нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, төсвийг сайжруулах, ашгийг нэмэгдүүлэх гэсэн санхүүгийн зорилтуудыг тодорхойлдог байна.
2. **Төсөв боловсруулах** (Develop Budget)**:** төсвийн орлого, зарлагыг тодорхойлсон төсвийг боловсруулахдаа байгууллагын газар, хэлтэс, бүтээгдэхүүний нэр төрөл, ангилалаар бодитой, хүрч болохуйц байдлаар төлөвлөнө.
3. **Төсвийг хэрэгжүүлэх:** (Implement the Budget): Төлөвлөсөн төсвийг зарцуулалтанд хяналт тавих бөгөөд төсвийн төлөвлөсөн зорилтыг хэрэгжүүлнэ.
4. **Гүйцэтгэлийг хянах** (Track Performance): Төсвийн гүйцэтгэлийг хянахдаа: төсвийн орлого, зарлагын бодит төсөвлөгдсөн төсвийн дүнтэй харьцуулан сар болон улирлаар тогтмол хяналт тавьдаг байна.
5. **Бодит үр дүнг төсөвтэй харьцуулах** (Compare Actual Result to Budget) энэ нь төсвийн орлого зарлагын бодит үр дүнг төсөвлөгдсөн төсвийн дүнтэй харьцуулалт хийдэг байна.
6. **Засах арга хэмжээ авах** (Take Corrective Action)**:** Төсвийн төлөвлөлтийн зорилтыг хэрэгжүүлээгүй тохиолдолд зарлагаа бууруулах, орлогыг нэмэгдүүлэх зарчмаар төсвийг өөрчлөн засах арга хэмжээ авдаг байна.

Зураг 1.Төсвийн хяналтын үйл явц дахь үе шатууд



Эх сурвалж: https://www.shiksha.com/online-courses/articles/budgetary-control-steps-objectives-and-advantages/

[20] *Steps in the Budgetary Control Process*
https://www.shiksha.com/online-courses/articles/budgetary-control-steps-objectives-and-advantages/


Төсвийн хяналтын давуу талууд[21]
(Advantages of Budgetary Control)

- **Санхүүгийн гүйцэтгэл сайжирна (**Improved Financial Performance): Төсвийн хяналт нь байгууллагуудын орлогыг нэмэгдүүлэх, зардлыг бууруулах, нөөцийг үр ашигтай, үр дүнтэй, ашигт ажиллагааг сайжруулсан байна.
- **Илүү сайн шийдвэр гаргах (**Better Decision-Making)**:** Төсвийн хяналт нь байгууллагуудад санхүүгийн үр дүнгээ илүү сайн ойлгох боломжийг бүрдүүлэх, нөөцийг зөв хуваарилах, бизнесийг хөгжүүлэх, эрсдэлийг удирдах талаар шийдвэр гаргах чадварыг сайжруулна.
- **Хариуцлагыг нэмэгдүүлэх (**Increased Accountability)**:** Төсвийн хяналт нь төсвийн хэрэгжилтийн явцад шийдвэрлээгүй байгаа асуудлыг илрүүлэх, төлөвлөсөн төсвийн зорилтуудыг биелүүлэх хариуцлагыг нэмэгдүүлдэг байна.
- **Зохицуулалт болон харилцан ойлголцол сайжирсан** (Improved Coordination and Communication)**:** Төсвийн хяналт нь зохион байгуулалтын хэлтэс, нэгжүүдийн хоорондын уялдаа холбоо, харилцаа холбоог сайжруулах бөгөөд төсвийн гүйцэтгэл нь санхүүгийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлдөг талаар зохицуулалтыг хийнэ.
- **Нөөцийг илүү үр ашигтай ашиглах (**More Efficient Use of Resources): Төсвийн хяналт нь байгууллагуудад зардлыг бууруулах, эсхүл танаж болох зардлыг тодорхойлсноор төсвийн нөөцийг илүү үр ашигтай ашиглах, дахин хөрөнгө оруулалт хийх, ашиг, орлогыг сайжруулахад хэмнэлт хийх зэрэг давуу талтай байдаг байна.

Дунд хугацааны төсвийн хүрээнд парламентаас тавих хяналт

Төсвийн ихэнх арга хэмжээ нь жилийн төсвөөс давсан үр дагавар бүхий арга хэмжээнүүд байдаг. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хувьд дунд хугацааны төсвийн хүрээнд парламентын зүгээс хяналт тавьдаг нийтлэг практик байна. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын хорин дөрвөн (24) парламентад дунд хугацааны төсвийн хүрээний хэлэлцүүлэг хийдэг бөгөөд эдгээрийн арван гурав (13) нь дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг албан ёсоор баталдаг байна[22].

График 1. Парламент дунд хугацааны төсвийн хүрээг хэлэлцдэг эсэх (хувиар



[21] *Төсвийн хяналтын давуу талууд*
https://www.shiksha.com/online-courses/articles/budgetary-control-steps-objectives-and-advantages/
[22] *Budgeting and Public Expenditures in OCED Countries, 2019*

Хүснэгт 6.Парламент дунд хугацааны төсвийн хүрээг хэлэлцэн баталдаг эсэх


Дунд хугацааны төсвийн хүрээг хэлэлцдэг, баталдаг эсэх	Улсын тоо	Улсын нэр
Хэлэлцэж баталдаг	13	Австри, Грек, Испани, ИБУИНХУ, Исланд, Израил, Итали, Канад, Латви, Словени, ХБНГУ, Финланд, Швед Хэлэлцдэг
Хэлэлцдэг	11	Австрали, Бельги, Дани, БНСУ, Нидерланд, Португал, Словак, Турк, Чех, Эстони, Япон
Хэлэлцдэггүй	6	АНУ, Люскембург, Норвег, Унгар, Франц, Шинэ Зеланд
Бусад	4	Ирланд, Польш, Чили, Швейцар

Эх сурвалж: (OECD,2019)

Урт хугацааны тогтвортой байдалд парламентаас тавих хяналт

Дунд хугацааны дүн шинжилгээ нь урт хугацааны дүн шинжилгээний үндэс болдог бөгөөд төрийн санхүүжилтийн тогтвортой байдлыг хангах, нийгэмд учирч болохуйц эрсдэл, төсөв хуваарилалтын тохиролцоо хийхийг илэрхийлэх хэрэгсэл юм. ЭЗХАХБ-ын ихэнх улс орнуудад урт хугацааны тогтвортой байдалд парламентаас төсөвт тавих хяналт ихэссэн байна.

График 2. Парламент урт хугацааны тогтвортой байдлын дүн шинжилгээг хүлээн авдаг эсэх



Төсвийн хараат бус байгууллагууд (ТХББ) (*Independent Fiscal Institution-IFI) нь* парламентын төсвийн бие даасан байгууллага юм. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудад Парламентын хэтийн урт хугацаа (10-50 жил)-тай төсөвт хөндлөнгийн хяналт тавих үүрэг хүлээдэг бөгөөд Парламентын төсвийн хэлэлцүүлэг нь ТХББ-ын дүн шинжилгээг хэлэлцэх онцгой боломжийг олгодог. ТХББ-ын үндсэн **чиг үүргүүд нь**: макро эдийн засаг, төсвийн хүрээний мэдэгдэл, төсөөлөл таамаглалыг гаргах, төсвийн төлөвлөгөө, үр дүнг хянах, үнэлэх, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн өртөг тооцох, урт хугацааны төсвийн тогтвортой байдалд дүн шинжилгээ хийх, парламентад төсвийн хяналт шинжилгээ хийхэд дэмжлэг үзүүлэх зэрэг чиг үүргүүдтэй байна. ТХББ-ын төсөвт хийх дүн шинжилгээг олон нийтэд ил тод болгосноор хариуцлагыг өндөржүүлж,

олон нийтийн хэлэлцүүлгийг нэмэгдүүлдэг байна[23]. ЭЗХАХБ-ын тайланд дурдснаар, ТХББ-ууд нь улс орон бүрд засаглалын хэлбэр, төрийн байгууламж, түүхэн уламжлалаас шалтгаалан тогтолцоо, чиг үүрэг харилцан адилгүй байна. Тухайлбал: АНУ, БНСУ (ерөнхийлөгчийн засаглалтай) Австрали, Канад, Гүрж зэрэг улсуудын ТХББ нь парламентын төсвийн алба, ажлын албаны нэгжтэй; Бельги, Хорват, Нидерланд, Их Британи Улсуудын ТХББ нь гүйцэтгэх засаглалын дэргэдэх нэгжтэй; Франц, Финланд улсуудын ТХББ нь Аудитын Дээд байгууллагын дэргэдэх нэгжтэй; Чек, Словак, Швед Улсуудын ТХББ нь бие даасан тусгай хуулиар байгуулагддаг байна.

Парламентад төсвийн хэлэлцүүлэгт урт хугацааны тогтвортой байдалд дүн шинжилгээ хийхийг хүлээн авч хэлэлцдэг талаар улс орон бүрд харилцан адилгүй байх боловч төсвийн ихэнх системд ижил төстэй нийтлэг талуудтай байна.

Хүснэгт 7.Парламент төсвийн хэлэлцүүлэгт урт хугацааны тогтвортой байдалд дүн шинжилгээг хүлээн авч хэлэлцдэг эсэх

Парламент урт хугацааны тогтвортой байдлын дүн шинжилгээг хүлээн авч, хэлэлцдэг эсэх	**Улсын тоо**	**Улсын нэр**
ТХББ-аас дүн шинжилгээг хүлээн авч хэлэлцдэг	3	Испани, ИБУИНХУ, Люскембург
ТХББ болон ЗГ-аас дүн шинжилгээ хүлээн авч хэлэлцдэг	9	Австрали, Канад, Дани, Франц, Грек, Итали, БНСУ, Нидерланд, Швед
Зөвхөн ЗГ-аас дүн шинжилгээ хүлээн авч хэлэлцдэг	6	Австри, Норвег, Турк, Шинэ Зеланд, Эстони, Япон
Дүн шинжилгээ хүлээн авдаггүй	10	Бельги, Чех, ХБНГУ, Унгар, Исланд, Израил, Латви, Португал, Словак, Словени
Бусад	6	АНУ, Ирланд, Польш, Финланд, Швейцар, Чили

Эх сурвалж: (Budgeting and Public Expenditures in OCED Countries, 2019)

Төсвийн Хороо (Budget Committee)

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын парламентын гуравны хоёрт төсвийн хороотой байдаг бөгөөд төсвийн ерөнхий хяналт, салбар хороодын саналыг зохицуулах үүрэгтэй байна. Найман (8) улсад төсвийн хороо нь төсвийн нийт дүнг авч үздэг бол салбарын хороод нь салбарын зардлуудыг авч хэлэлцдэг байна. Зөвхөн Австрали, Их Британи Улсуудад төсвийн хороотой дүйцэх бүтэц байдаггүй байна. Австрали Улсад Парламентын доод танхимын хороод нь бараг үүрэг гүйцэтгэдэггүй бөгөөд төсвийн хяналтыг Сенатад үнэлгээний сонсголоор голчлон явуулдаг байна.

ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын дийлэнх нь гүйцэтгэлийн мэдээллийг төсөв боловсруулахдаа ашигладаг байна. Холбогдох асуудлаар ихээхэн туршлага хуримтлуулсан салбарын асуудал эрхэлсэн хороод өөрсдийн эрхэлсэн асуудлын төсвийн багцын гүйцэтгэлийн мэдээллийг хянаж үзэхэд илүү тохиромжтой байдаг. Харин ХБНГУ-ын Төсвийн хорооны илтгэгчийн тогтолцоо (*Budget Committee's rapporteur system*) нь салбарын асуудал эрхэлсэн хороодын оролцоогүйгээр төсвийн

[23] *IMF Fiscal monitor, 2024*

хороо нь төсвийн талаар ихээхэн мэдлэг, туршлага хуримтлуулж болдгийг харуулж байна. ЭЗХАХБ-ын гишүүн 21 хууль тогтоох байгууллагад төсөвт хавсаргасан гүйцэтгэлийн мэдээллийг хянах үндсэн үүргийг Төсвийн хороо/эсхүл Төсвийн хорооны дэд хороо хүлээдэг байна. Зөвхөн 11 улсад салбарын асуудал эрхэлсэн хороод тэргүүлэх үүргийг гүйцэтгэдэг байна. Грек, Итали Улсууд Төсвийн хороо, салбарын асуудал эрхэлсэн хороод хоёулаа тэргүүлдэг байна. Вестминстер загварын парламентуудын төрийн хариуцлагын хороодод Франц, Герман, Унгар, Португал, Испани зэрэг улсууд хамрагддаг байна.

Төсвийн гүйцэтгэлийн хяналт (EX POST)

Парламент нь төсвийн гүйцэтгэлд хяналт тавьдаг. Төсвийн гүйцэтгэлд тавих хяналтыг тухайн жилийн төсвийн зарцуулалтын талаарх мэдээллээр хангадаг аудитын тайланг үндэслэдэг. ЭЗХАХБ-ын “Төсвийн ил тод байдлын сайн туршлага” тайланд ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 70 орчим хувь нь төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр гаргадаг бөгөөд хагас жилд дэлгэрэнгүй байдлаар тоймлодог. Цөөн хэдэн улс (30% орчим) нь төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал бүр тайлагнадаг байна. ЭЗХАХБ-ын гишүүн орнуудын 75 гаруй хувь нь төсвийн тодотголыг хууль тогтоомжоор баталдаг. Парламентад хяналт шалгалт хийх, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулсан, бодлого нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэхийг Аудит хянадаг. ЭЗХАХБ-ын олон парламентуудад Аудитын дээд байгууллагаас гаргасан тайлангуудыг хянан шийдвэрлэх үүрэг бүхий тусгайлсан Аудитын хороо буюу Төрийн хариуцлагын хороо (*Public Accounts Committee*) гүйцэтгэдэг. Төсвийн хяналтыг Төсвийн хороо, түүний дэд хороод гүйцэтгэдэг.

Төсвийн хороо[24] (Budget Committee) нь парламентын хууль тогтоомжийн төсвийн үйл ажиллагааны уялдаа холбоо, төсвийн сахилга бат, парламентаас баталсан төсвийн нийт хуваарилалт, төсвийн тодотголыг хянах, салбар хороодын асуудлыг нэгдсэн хуралдаанд нэгтгэн оруулах, тайланд тусган хянах, Аудитын дээд байгууллагаас гаргасан тайлан хянах, Парламентын алба, Төсвийн зөвлөл, намаас үл хамааран төсвийн бодлого, дүн шинжилгээ, судалгаа хийх, стратеги төлөвлөгөө, төсвийн төсөөллийг үнэлэх, төсвийн бодлогын ил тод байдлыг хангах, парламент болон түүний хороодод дэмжлэг үзүүлэх чиг үүрэгтэй байна.

Аудитын хороо (Audit Committee) нь төсвийн болон санхүүгийн тайлан, эрсдэлийн удирдлага, хяналтын үйл явц, үр нөлөөг үнэлэх, төсвийн зарцуулалтыг парламентаас баталсан төсөвтэй уялдуулсан эсэх, төсвийн зарцуулалтын үр ашиг, хэмнэлт зэрэг төрийн бодлогыг хараат бусаар хэрэгжүүлэх чиг үүрэгтэй байна.

Төрийн хариуцлагын хороо (Public Accounts Committee)-нь: Парламентын хяналтын хороо юм. Энэ хороо нь төсвийг батлахаас өмнөх хэлэлцэх үе шатуудыг хянан шалгах, үнэлэх, төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, төсвийн зарцуулалтын


[24] *OECD Best Practices for Parliaments in Budgeting.2023* https://www.pbo.gov.au/sites/default/files/2023-05/OECD%20Best%20Practices%20for%20Parliaments%20in%20Budgeting%20Jan%202023.pdf

хэмнэлт, үр ашиг, бүтээмжтэй эсэх, үр дүнг ил тод, шударга үнэлэх чиг үүрэгтэй. Ихэвчлэн сөрөг хүчин, цөөнхийн нам (парламент)-ын гишүүдээс бүрдсэн байна.

Төсвийн зөвлөл (Budget Council)-ийг сүүлийн үед 50 гаруй улс орнууд байгуулжээ. Төсвийн зөвлөл нь макро эдийн засаг болон төсвийн төсөөлөл, таамаглалыг боловсруулах; төсвийн бодлогын дүрмийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх; төсвийн бодлогын өртөг зардлыг тооцох; урт болон богино, дунд хугацааны тогтвортой байдлыг хангах, Засгийн газрын төсвийн бодлого, макро эдийн засгийн зорилтуудтай уялдуулан төсвийн гүйцэтгэлд хяналт тавих, хөндлөнгийн зүгээс үнэлэлт, дүгнэлт хийх, төсвийн бодлогыг оновчтой байлгах хувилбаруудыг тодорхойлох, бодлогын зөвлөмж боловсруулах зэрэг чиг үүрэгтэй.

Бие даасан Аудитын дээд байгууллага (*Independent Supreme Audit Institutions*)[25] нь бие даасан төрийн байгууллага бөгөөд төсвийн орлого зарлагад хяналт шалгалт хийг зөвлөмж өгөх чиг үүрэгтэй. ЕХ-ны 27 гишүүн улс төсвийн зарцуулалт, ил тод байдал, хариуцлага, хатуу хяналтын зохицуулалтыг хэрэгжүүлдэг байна. Улс орнуудын Аудитын дээд байгууллага нь хараат бус, бодитой, шударга байдлыг эрхэмлэн, улсын нөөцийг үр ашигтай, хэмнэлттэй ашиглах, төсвийн зарцуулалт, орлогын бүрдүүлэлт нь холбогдох хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийдэг байна. Австри, Дани, Финланд, Унгар, Литв, Малта, Польш, Испани Швед Ирланд Улсуудад Аудитын дээд байгууллага нь парламентын хяналтын бүтцийн нэг хэсэг болдог байна.

График 3.Парламентад өргөн мэдүүлдэг төсвийн тодотгол, тайлангууд



Эх сурвалж: УИХТГ-ын ПСХХ-ийн "Парламентын төсөв санхүүгийн хяналт, олон улсын туршлага" харьцуулсан судалгаа

Зарим улс орнуудад аудитын болон дараагийн төсөв батлах үе шат хоорондын уялдаа холбоог бэхжүүлсэн туршлагууд байна. Тухайлбал, ХБНГУ-д Аудитын байгууллагын төлөөлөгч, Төсвийн хороо болон яамны мэргэжилтнүүдийн зөвлөлдөх уулзалтад тайлан болон нэмэлт, өөрчлөлтийг танилцуулдаг байна. Австри Улсын төсвийн тайланд зардлын чиглэлүүдийг Аудитын шүүхийн зөвлөмжүүдийг оруулсан байдаг. Франц Улсад Санхүүгийн хорооны мэргэшсэн гишүүд нь аудитын дүгнэлтийг төсвийн хэлэлцүүлэгт хангуулах үүрэг хүлээдэг байна.

[25] *ЕХ гишүүн орнуудын аудитын дээд байгууллага https://op.europa.eu/webpub/eca/book-state-audit/en/*

2023 онд “ЭЗХАХБ-ын Парламентуудын төсвийн талаарх шилдэг туршлага[26]” (OECD Best Practices for Parliaments in Budgeting) тайланд төсвийн үйл явцад **иргэдийн оролцоог** нэмэгдүүлэх талаар дурдсан байна. Парламент болон түүний хороод төсөв хэлэлцэх асуудлаар иргэний нийгэм болон эмзэг бүлгийн иргэдийн төлөөллийг татан оролцуулж, төсвийн хэлэлцүүлэгт үзэл бодлоо илэрхийлэх, олон нийтийн сонсгол, орчин үеийн дижитал технологи, инновацыг дэмжих, иргэдийн зөвлөл, хурлын төлөөлөлтэй зөвлөлдөх, хяналт тавих үйл ажиллагааг дэмждэг байна.

Төсвийн гүйцэтгэлд хяналт хийх байгууллагууд:

- Сангийн яам (*Finance ministry or treasury*) нь: төсвийн бодлого боловсруулах, төсвийн хэрэгжилтэд хяналт тавих үндсэн үүргийг гүйцэтгэдэг.
- Бие даасан Аудитын дээд байгууллагууд (*Independent supreme audit institutions*) нь: Засгийн газар, хууль тогтоох байгууллагаас баталсан төсөв бодитой эсэх, хуульд заасны дагуу төсвийг зарцуулалтыг хянан шалгадаг байна.
- Судалгааны төвүүд болон иргэний нийгмийн байгууллагууд (*Civil society organizations*) нь төсвийн үйл явц, төсвийн гүйцэтгэлд хяналт хийж, ажиглагдаагүй өөр өнцгөөс хараат бус, бие даасан байдлаар төсвийг хянаж, дүгнэлт гаргадаг байна.
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл (*The media*)нь: төсвийн хэлэлцүүлэг, төсвийн гүйцэтгэлийн талаар олон нийтэд мэдээллийг ил тод хүргэх, парламент болон байнгын хороодод чөлөөтэй нэвтрэх эрхтэй байна.
- Олон улсын санхүүгийн байгууллагууд болон донор байгууллагууд (*International financial institutions and donor agencies*) нь гадаад улсад өр ихтэй, ядуу буурай орнуудын төсвийн үйл явц, төсвийн гүйцэтгэлийн үед хяналт тавих үүрэгтэй оролцдог байна.

ЕХ-ны гишүүн орнуудын “Төсвийн хяналт шалгалт хийхэд парламентын үүрэг оролцоо” сэдэвт хамтарсан тайланд дараах асуудлуудыг парламент үүргээ хэрэгжүүлэх талаар зөвлөмж өгсөн байна.
Үүнд:[27]

- Парламентын санхүүгийн хяналтыг цаашид хөгжүүлэх талаар төсөөлөлтэй байх;
- Төсвийн зарлагын асуудлаар гишүүдэд төсвийн өмнө хэлэлцүүлэг явуулах;
- Татвар, төсвийн зарцуулалтын нарийвчилсан төлөвлөгөөг төрийн бодлоготой уялдуулан танилцуулах;
- Санхүүгийн хороодын чиг үүргийг бэхжүүлэх, төсвийн үйл явцад голлох байр суурийг эзлэх;
- Парламентын хороодын төсвийн тухай хуулийг хэлэлцэх чадамжаа нэмэгдүүлэх;

[26] *OECD Best Practices for Parliaments in Budgeting.2023* https://www.pbo.gov.au/sites/default/files/2023-05/OECD%20Best%20Practices%20for%20Parliaments%20in%20Budgeting%20Jan%202023.pdf
[27] *The role of the Parliament in the Budget scrutiny process, 2019* https://www.sobranie.mk/content/%D0%9F%D0%B0%D1%80%D0%BB%D0%B0%D0%BC%D0%B5%D0%BD%D1%82%D0%B0%D1%80%D0%B5%D0%BD%20%D0%B8%D0%BD%D1%81%D1%82%D0%B8%D1%82%D1%83%D1%82/Billateral%20research%20Macedonia%20and%20Czechia%2012,19.pdf

- Парламентаас зарцуулалтыг батлах хөтөлбөрүүдийн санхүүгийн зардлыг хавсаргах;
- Засгийн газраас төсвийн жилд дэвшүүлсэн гүйцэтгэлийн зорилтыг хавсаргах;
- Төсвийн хороод болон алба, нэгжүүд бие даасан, эрх мэдэлтэй, хараат бус байх,парламентын мэргэжилтнүүд төсвийн талаарх эдийн засгийн тооцоо, шинжилгээг хавсаргах;
- Парламент нь төсөв боловсруулах үйл явцад жендерийн оролцоог нэмэгдүүлэх хувилбарыг судалж, жендерийн нөлөөллийн үнэлгээг үндэслэнэ.

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ТӨСӨВ ХЯНАХТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ТОГТООМЖУУД

Монгол Улсын хувьд төсвийн хяналттай холбоотой хууль эрх зүйн орчин нь Үндсэн хууль, Улсын Их Хурлын тухай хууль, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль, Улсын Их Хурлын хянан шалгалтын тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Төсвийн тухай хуулиудаас бүрдэнэ. Тухайлбал:

Үндсэн хууль[28] Уг хуулийн 3 дугаар бүлгийн 25 дугаар зүйлийн 7 хэсэгт зааснаар: “Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллагын бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно” гэж тусгасан байна.

Улсын Их Хурлын тухай хууль[29] **(шинэчилсэн найруулга, 2024).** Энэхүү хуулийн 26 дугаар зүйлд төсөвтэй холбоотой асуудлыг Байнгын хорооны даргын чиг үүрэгт, 27 зүйлд Байнгын хорооны харьяанд түүний эрхлэх асуудлын хүрээнд тодорхой хэсгийг дагнах хариуцах үүрэг бүхий Төсвийн зарлагын дэд хороо, 28 дугаар зүйлд УИХ-ын тогтоолоор хянан шалгах түр хороог 6 сарын хугацаатайгаар байгуулах тухай тус тус тусгасан байна. Мөн хуулийн 37 зүйлийн 37.1 дэх хэсэгт зааснаар УИХ хянан шалгах бүрэн эрхийг дараах арга хэрэгслээр хэрэгжүүлдэг байна. Үүнд: асуулт болон асуулга тавих; хууль тогтоомжийн биелэлтийн үр дагаварт үнэлгээ хийх, мэдээлэл сонсох, тайлан, илтгэл хэлэлцэх; төсвийн хяналт; Улсын Их Хурлын хяналтын сонсгол хийх; Үндсэн хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хянан шалгах түр хороо байгуулж, тусгай шалгалт явуулах гэсэн 7 арга хэрэгслийг ашиглан хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлдэг байна. Энэ хуулийн 52 дугаар зүйлд төсвийг зарцуулах, гүйцэтгэлд тавих хяналтын талаар “УИХ-ыг төсвийг Ерөнхий нарийн бичгийн дарга зориулалтын дагуу захиран зарцуулна. Улсын Их Хурал жилийн эцсийн санхүүгийн тайлангаа дараа жилийн 04 дүгээр сарын 05-ны өдрийн дотор Төрийн аудитын төв байгууллагад хүргүүлнэ. Төрийн аудитын төв байгууллага тайланг хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор тайлангийн талаар аудитын дүгнэлт гаргана. УИХ-ын төсвийн гүйцэтгэлийн тайлан, энэ хуулийн 52.2-т заасан төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороо (ТББХ)-ны хуралдаанаар хэлэлцэнэ“ гэж тусгасан байна.

УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль (шинэчилсэн найруулга, 2024) УИХ-ын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 9 дүгээр бүлгийн 69-74 дүгээр зүйлд улсын төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журмыг тусгасан байна. Уг хуулийн 69.2 дахь хэсэгт заасан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төсөлд хяналтын сонсгол явуулах бол хоёр дахь хэлэлцүүлгийн өмнө төсвийн төслийн цаглаварт нийцүүлэн Төсвийн байнгын хороо сонсгол зохион байгуулах тухай, 71 дүгээр зүйлийн 71.1 дэх хэсэгт заасан төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэгт, Төсвийн болон бусад Байнгын хороо,

---

[28] *МУ-ын Үндсэн хууль* https://legalinfo.mn/mn/detail?lawId=367

[29] *УИХ-ын тухай хууль, 2024* https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140610916031

Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд, нам, эвслийн бүлэг төсвийн төслийг хэлэлцэх тухай, 71.4 дэх хэсэгт бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэх тухай, 71.4.3 дахь заалтад Байнгын хороод, нам эвслийн бүлэг санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд өгөх, дэд хороо нь санад дүгнэлтээ нэгтгэн гаргасан санал дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах тухай, 74 дүгээр зүйлд заасан газар, улсын төсвийн гүйцэтгэл батлах тогтоолын төсөл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, ЗГ-ын санхүүгийн нэгтгэсэн тайлан УИХ-д өргөн мэдүүлнэ. Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагч нар, Ерөнхий аудитор байлцах тухай тус тус заасан байна. Мөн хуулийн 95.5.3 дахь заалтад Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах тухай, 95.5.5 дахь заалтад олон нийтийн хэлэлцүүлэг, Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах тухай тус тус дурджээ.

УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль (шинэчилсэн найруулга, 2024)

Энэхүү хуулийн 3 дугаар бүлгийн 3.1.4 дэх заалтад заасан төсөв боловсруулах, батлах, хэрэгжүүлэх шатанд хяналт тавих, төсвийн сахилга батыг хангуулна гэж тусгасан байна. УИХ хянан шалгах бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ: хараат бус, бодитой, иж бүрэн мэдээлэлд тулгуурлах, ард түмний нийтлэг ашиг сонирхлыг дээдлэх, ил тод байх гэсэн зарчмыг баримтлана[30]. УИХ-ын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санг УИХ-ын Тамгын газар бүрдүүлж, эрхлэн хөтөлнө.[31] Байнгын хороо, хянан шалгах түр хороо, УИХ-ын гишүүн, УИХ-аас хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих үйл ажиллагааг хэрэгжүүлнэ. УИХ-ын хянан шалгалтыг төлөвлөгөөт, төлөвлөгөөт бус гэсэн хоёр төрөлтэй байна. УИХ-аас төсөвт тавих үйл ажиллагаанд тасралтгүй, байнгынх байх; ил тод, нээлттэй байх; үр нөлөөтэй байх; зохистой байх; олон нийтийн оролцоог хангасан байх гэсэн зарчмыг баримтлана.[32]

УИХ-ын төсвийн хяналтыг:

а) төсвийн төслийн боловсруулалтын үе шатанд тавих хяналт;

б) Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн төслийн хэлэлцүүлгийн үе шатанд тавих хяналт; в) төсвийн хэрэгжилтэд тавих хяналт гэсэн 3 хэлбэрээр хэрэгжүүлнэ[33]. Төсвийн төслийн хяналт нь: нэг дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт, хоёр дахь хэлээлцүүлгийн үе шатны хяналт гэсэн 2 үе шаттай байна.[34]

<u>Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийн үе шатны хяналт</u>

Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөл хуулийн 23 дугаар зүйлд дараах шаардлагыг хангасан эсэхэд хяналт тавина:

- төсвийн төсөл нь улсын хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэх;

[30] *УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 4 дүгээр зүйл.*
[31] *УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйл.*
[32] *УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйл*
[33] *Мөн хуулийн 21.2*
[34] *Мөн хуулийн 21.3*

- Төсвийн тухай хууль болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуурыг хангасан эсэх;
- Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн эсэх;
- Энэ хуулийн 23.1-д заасан асуудлаарх Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг Улсын Их Хуралд ирүүлсэн даруйд гишүүдэд хүргүүлнэ;
- Энэ хуулийн 23.2-т заасан дүгнэлтийг Улсын Их Хурал нэг дэх хэлэлцүүлгээс төсвийн төслийг Үндсэн хууль, холбогдох хуульд нийцүүлэх чиглэл өгч зөвхөн нэг удаа Засгийн газарт буцаана;
- Засгийн газар Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан хугацаанд төсвийн төслийг хуульд нийцүүлэн дахин боловсруулж, Улсын Их Хуралд ирүүлнэ;
- Улсын Их Хурал төсвийн төслийн талаар олон нийтийн хэлэлцүүлэг хийж болно.

Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатны хяналт

- Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд түүнд тавих хяналтыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 71 дүгээр зүйлд заасны дагуу хэрэгжүүлнэ.
- Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд төсвийн төсөлд тусгуулахаар гаргасан санал энэ хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэхэд Тамгын газрын төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгж дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган, төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд уг дүгнэлтийг гишүүдэд хүргүүлнэ.
- Хоёр дахь хэлэлцүүлгийн үе шатанд Тамгын газрын төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгж Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Төсвийн байнгын хороог шаардлагатай тооцоо, мэдээллээр хангаж ажиллана.

Төсвийн гүйцэтгэлд тавих хяналт

Улсын Их Хурал төсвийн хэрэгжилтэд тавих хяналтыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн талаарх санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг хэлэлцэх;
- шаардлагатай гэж үзвэл энэ хуульд болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасны дагуу тухайн жилийн төсвийн хуулийн хэрэгжилтийн талаар төсвийн хяналтын сонсгол зохион байгуулах;
- шаардлагатай гэж үзвэл төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсэг байгуулан ажиллуулах, дүнг сонсох, хэлэлцэх;
- хуульд заасан бусад хэлбэр.
- тухайн жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл төсвийн хууль тогтоомжид нийцсэн эсэх, түүнчлэн тухайн жилийн улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд заасан зорилго, зорилт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн эсэхэд Улсын Их Хурал хяналт тавина.

- Сар, улирал, хагас жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг эрх бүхий байгууллага, албан тушаалтан Улсын Их Хуралд тухай бүр ирүүлэх бөгөөд хагас жилийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлд ажлын 14 өдрийн дотор Тамгын газрын төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгж дүн шинжилгээ хийж, дүгнэлт, саналын хамт Улсын Их Хурлын гишүүд, холбогдох Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ. Холбогдох Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо шаардлагатай гэж үзвэл төсвийн гүйцэтгэлийн явцын тайланг хэлэлцэж болно.
- Улсын Их Хурал энэ хуулийн 25.1.1-д заасан жилийн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Засгийн газарт төсвийн хууль тогтоомжийг хэрэгжүүлэх арга хэмжээний талаар тодорхой чиглэл өгч болно.
- Засгийн газар энэ хуулийн 25.4-т заасан Улсын Их Хурлын тогтоолыг биелүүлэхээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ болон үр дүнгийн талаар уг тогтоолд заасан хугацаанд Улсын Их Хуралд танилцуулах үүрэгтэй.

Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төсөлд хяналтын сонсгол явуулах бол хоёр дахь хэлэлцүүлгийн өмнө төсвийн төслийн цаглаварт нийцүүлэн Төсвийн байнгын хороо сонсгол зохион байгуулж болно. УИХ-ын хяналтын сонсгол нь: хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсгол, төсвийн хяналтын сонсгол, ерөнхий хяналтын сонсгол, нэр дэвшигчийн сонсгол гэсэн төрөлтэй байна.

Төрийн аудитын тухай хууль (шинэчилсэн найруулга) Төрийн аудитад хууль дээдлэх, хараат бус, бие даасан байх, шударга ёсыг хангах, мэдээллээр бүрэн хангагдах, ил тод, бодитой байх, төрийн аудитын олон улсын нийтлэг стандартад нийцсэн байх зарчмыг баримтална. Төрийн санхүү, төсвийн хяналтыг хараат бусаар хэрэгжүүлэх байгууллага нь төрийн аудитын байгууллага байна[35]. Төрийн аудитын байгууллага төрийн санхүү, төсвийн хяналтын хүрээнд санхүүгийн тайлангийн аудит, гүйцэтгэлийн аудит, нийцлийн аудит гэсэн төрлөөр аудит хийнэ.[36] *Санхүүгийн тайлангийн аудит нь* Төсвийн тухай хуульд заасны дагуу улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн байгууллага, төсөв захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, санхүүгийн нэгтгэсэн тайлан, төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн санхүүгийн аудит хийнэ. *Гүйцэтгэлийн аудит нь:* Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээдийн бодлого, үйл ажиллагаа, чиг үүргийн хэрэгжилт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний гүйцэтгэл нь арвилан хэмнэлт, үр ашиг, үр нөлөөтэй эсэхэд аудит хийнэ. *Нийцлийн аудит нь:* Төрийн аудитын байгууллага шалгагдагч этгээд үйл ажиллагаандаа төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актыг хэрэгжүүлж байгаа эсэхэд аудит хийнэ. Төрийн аудитын байгууллага нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн болон гүйцэтгэлийн аудиттай хослуулан хийж болно.

[35] *Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл*
[36] *мөн хуулийн 2 бүлэг,7.1.1*

Төсвийн тухай хууль

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасны дагуу төсвийн ил тод байдлыг хангасан байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ:

- төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нийтэд нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын талаар тогтоосон хугацаанд нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх;
- төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах;
- төсвийн гүйцэтгэл, зарцуулалт нь батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт хяналт тавих боломжоор хангах;
- төрөөс үзүүлж байгаа аливаа ажил, үйлчилгээ, хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, тэдгээрийн хүрээнд худалдан авч байгаа бараа, ажил, үйлчилгээнд олон нийт хяналт тавих боломжоор хангах.

Төсвийг нэг жилээр баталж, тайлагнах бөгөөд батлагдсан төсвийг сар, улирлаар хуваарилан, хэрэгжилтийг зохион байгуулна. Төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрээр, санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг улирал, хагас жил, бүтэн жилээр бэлтгэж, тайлагнана.

Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталсан өдрөөс эхлэн зохион байгуулж болно. Төсвийн жил эхлэхэд төсвийн захирагчийн тухайн төсвийн жилийн батлагдсан төсвийг зарцуулах эрх нь нээгдэнэ[37].

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаар Төсвийн шууд захирагч улирлын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа улирлын эхний сарын 15-ны дотор гаргаж харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ. Төсвийн төвлөрүүлэн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор гаргаж төсвийн ерөнхийлөн захирагчид, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 3 дугаар сарын 05-ны өдрийн дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 3 дугаар сарын 25-ны өдрийн дотор төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлдэг байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 05-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн

[37] *Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйл*

төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 25-ны дотор гаргана. Төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 15-ны дотор гаргаж, төрийн аудитын төв байгууллагад хүргүүлэх ба төрийн аудитын төв байгууллага 5 дугаар сарын 05-ны дотор аудит хийж, санал дүгнэлт гаргана.

Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 5 дугаар сарын 10-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлдэг. Төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын өрийн тайлан, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, УИХ-д хүргүүлнэ.

Гурав.ГАДААДЫН БУСАД ОРНЫ ТУРШЛАГА

3.1 ШИНЭ ЗЕЛАНД УЛС

Шинэ Зелланд нь Үндсэн хуульт хаант улс бөгөөд парламентын засаглалын систем бүхий ардчилсан төрийн тогтолцоотой. Шинэ Зеландын парламент нь нэг танхимтай ба Төлөөлөгчдийн танхим гэж нэрлэдэг.

Засгийн газрын төсөв нь Шинэ Зеландын төрийн санхүүгийн цөм нь болдог. Засгийн газар төсвийг боловсруулж, хэрэгжүүлдэг бол парламент нь төсвийг баталж, хяналт тавьдаг байна.

Төсвийг төлөвлөх, хэлэлцэх, батлах

Шинэ Зеландын Засгийн газрын төсөв 1 жилийн хугацаатай байх бөгөөд төсвийн жил 7 сарын 01-нээс дараа жилийн 6 сарын 30-ны өдрийг дуустал үргэлжилнэ. Төрийн санхүүгийн тухай хуульд зааснаар Засгийн газар ирэх жилийн Төсвийн төслийг 7 сарын 31-ний дотор парламентад өргөн барьж хэлэлцүүлэх ёстой байдаг боловч практикт 5 сард өргөн барьдаг. Төсвийг төлөвлөх, боловсруулах, хэлэлцэх, батлах үйл явц нь 6 үе шаттай байна.

Зураг 2.Төсвийг төлөвлөх, боловсруулах, хэлэлцэж батлах үе шат[38]



Төсвийн төслийг боловсруулах болон батлахдаа бэлтгэдэг баримт бичгүүд болон тэдгээрийг ямар хугацаанд бэлтгэдэг талаар доорх хүснэгтэд харуулав.

[38] *The Treasury, https://www.treasury.govt.nz/publications/guide/putting-it-together-explanatory-guide-new-zealands-state-sector-financial-management-system#planning-and-budgeting*

Хүснэгт 8.Төсвийн төслийг боловсруулах, батлах үйл явц

	Бэлтгэх хугацаа	Тайлант он	Төсвийн жил	Төсвийн жил + 1 жил	Төсвийн жил + 2 жил	Урт хугацаа (10-40 жил)
Хагас жилийн эдийн засгийн шинэчилсэн үнэлгээ, төсвийн тодотгол	XI – XII сар	Ихэвчлэн 3 жилээр				
Төсвийн бодлогын баримт бичиг	III сарын 31-ний дотор					
Төсвийн хүлээгдэж буй гүйцэтгэл	Ихэвчлэн төсвийн төсөлтэй хамт					
Төсвийн төсөл • **Төсвийн танилцуулга** • **Төсвийн стратеги** • **Төсөв, эдийн засгийн үндэслэл** • **Төсвийн орлого, зарлагын төсөөлөл** • **Төсвийн зардлын задаргааны тайлбар** • **Яамд, нэгжүүдийн төлөвлөгөө**	V сард	10 ба түүнээс дээш жилээр Тайлант он + 2 эсвэл 3 жилээр Тайлант он + 2 эсвэл 3 жилээр				
Урт хугацааны төсвийн төсөөлөл	Дор хаяж 4 жилд нэг удаа	10 ба түүнээс дээш жилээр				


Эх сурвалж: The Treasury, https://www.treasury.govt.nz/publications/guide/putting-it-together-explanatory-guide-new-zealands-state-sector-financial-management-system#planning-and-budgeting

Төсвийг өргөн барьж, батлуулах

Сангийн яам нь Засгийн газрын санхүүгийн бодлогыг тодорхойлж батлуулдаг Засгийн газрын гол бүтэц юм. Сангийн яам нь Төсвийн төслийг боловсруулж, гүйцэтгэлийг нь хангуулж, Засгийн газрын санхүүгийн тайлан бэлтгэнэ. Харин Төлөөлөгчдийн танхимын Санхүү, зарлагын байнгын хороо нь Төсвийн төслийг хэлэлцэж, төсвийн хяналтыг хэрэгжүүлдэг парламентын гол бүтэц юм.

Төрийн санхүүгийн хуулиар Төсвийн бодлогын баримт бичгийг 3 сарын 31-нээс өмнө Санхүү, зарлагын байнгын хороогоор хянуулж парламентаар хэлэлцүүлэх үүрэгтэй. Төсвийн төслийг 7 сарын 31-ний дотор парламентад өргөн барих ёстой байдаг. Гэхдээ практикт Засгийн газраас Төсвийн төслийг 5 сард өргөн барьдаг. Парламентаар Төсвийн төслийн 3 хэлэлцүүлгийг явуулна.

Зураг 3.Төсвийн төслийн хэлэлцүүлэг



Төсвийн эхний хэлэлцүүлэг нь Төсвийн төслийг хүргүүлснээс хойш нэг хоногийн дараа болдог бөгөөд энэ өдрийг Төсвийн өдөр (Budget Day) гэж нэрлэнэ. Эхний хэлэлцүүлэгт Сангийн сайд Төсвийн төслийг танилцуулж, төсвийн төслийг парламентад өргөн барина. Ингэснээр Төсвийн төслийн эхний хэлэлцүүлэг дуусаж хоёр дахь хэлэлцүүлэгт шилжинэ.

Хоёр дахь хэлэлцүүлгийг Төсвийн хэлэлцүүлэг гэнэ. Хоёр дахь хэлэлцүүлэгт Төсвийн стратеги, Төсвийн эдийн засгийн үндэслэл болон Төсвийн орлого, зарлагын төсөөллийг Санхүү, зарлагын байнгын хороонд хянан хэлэлцүүлэхээр шилжүүлнэ. Санхүү, зарлагын хороо нь Төсвийн орлого, зарлагын төсөөллийг хянаж, зарлага тус бүрийг хэлэлцүүлэгт оруулахаар холбогдох байнгын хороодод илгээнэ. Санхүү, зарлагын байнгын хороо болон холбогдох байнгын хороод нь харьяалах Засгийн газрын гишүүдээс төсвийн зарлагатай холбогдуулан тайлбар авна. Санхүү, зарлагын болон холбогдох байнгын хороод нь Төсвийн төсөөллийг 2 сарын хугацаанд багтааж парламентын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

Гурав дахь хэлэлцүүлэгт Төсвийн стратеги, Төсвийн эдийн засгийн үндэслэл, Төсвийн орлого, зарлагын төсөөлөл болон Санхүү, зарлагын байнгын хорооны тайланг парламент хэлэлцэж баталснаар Төсвийн хууль хүчин төгөлдөр болно.

Засгийн газрын санхүүгийн хориг тавих[39]

Шинэ Зеландын төсөв батлах үйл явцын нэг онцлог нь Засгийн газрын хориг тавих эрх юм. Парламентын гишүүд Төсвийн зарлага, татварын хувь хэмжээтэй холбоотой санал гаргаж парламентаар хэлэлцүүлэх эрхтэй байдаг. Хэрэв парламентын гишүүдийн дэвшүүлж, хэлэлцүүлсэн санал нь Төсвийн тэнцэл болон төсвийн төслийн зарлагад нөлөөлж байна гэж үзвэл Засгийн газар энэхүү саналд хориг тавих эрхтэй.

Сангийн сайд эсвэл холбогдох сайдын хүсэлтээр Засгийн газраас санхүүгийн хориг тавьж болно. Холбогдох сайд нь парламентаар хэлэлцүүлэгдэж буй саналтай танилцаж хориг тавих шаардлагатай гэвэл Сангийн сайдад хүсэлт гаргана. Засгийн газраас Санхүүгийн хоригийн сертификатыг парламентад хүргүүлснээр Засгийн газраас санхүүгийн хориг тавигдсанд тооцогдоно. Санхүүгийн хоригийн сертификатад Сангийн сайд гарын үсэг зурна.

[39] *Standing orders 2023, Chapter 6.Financial procedures, https://www.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders-2023-by-chapter/chapter-6-financial-procedures/*

Хүснэгт 9.Санхүүгийн хоригийн сертификат хүргүүлэх хугацаа

Парламентын гишүүний гаргасан санал	Санхүүгийн хоригийн сертификат хүргүүлэх хугацаа
Шинэ хууль санаачлах	Хуулийн гурав дахь хэлэлцүүлгийн өмнө
Одоо даган мөрдөж буй хуульд өөрчлөлт оруулах	Өөрчлөлтөөр санал хураалгахаас өмнө
Заавал дагаж мөрдөх хууль, тогтоолын төсөл батлуулах	Төслөөр санал хураалгахаас өмнө
Төсвийн төслийн орлого, зарлагад өөрчлөлт оруулах	Өөрчлөлт оруулах зарлагын төрлөөр санал хураалгахаас өмнө

Төсвийн гүйцэтгэлд тавигдах хяналт

Төсвийн гүйцэтгэлийн хяналт нь төсвийн үр ашгийг дээшлүүлж, зөв шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх зорилго бүхий тайлагнах, хянах, санхүүгийн сахилга батыг хангах үйл ажиллагааг агуулсан хяналтын тогтолцоо юм.

Төсвийн гүйцэтгэлийн хяналтын тогтолцоо нь эрх зүйн орчин, санхүүгийн мэдээллийн систем, хяналтын үйл ажиллагаа болон оролцогч талуудыг хамарсан байна. ,

Төсвийн гүйцэтгэлд хяналт тавих эрх зүйн орчин

Шинэ Зеландын төсөв болон төсвийн хэрэгжилтийн талаарх хууль эрх зүйн орчин нь Төрийн санхүүгийн тухай хууль, Төрийн аудитын тухай хууль, Парламентын дэгийн тухай хууль, Төрийн захиргааны тухай хууль, Төрийн байгууллагын тухай хууль, Төрийн өмчит аж ахуйн нэгжийн тухай хуулиудаас бүрдэнэ. Эдгээрээс төсөв, төсвийн гүйцэтгэл, хяналттай холбоотой гол гурван хуулийг авч үзье.

1. Төрийн санхүүгийн тухай хууль[40]

Төрийн санхүүгийн тухай хууль нь 1989 онд батлагдсан бөгөөд төсвийн харилцааг зохицуулсан гол хууль юм. Төрийн санхүүгийн тухай хуулиар төсвийн сахилга батыг хангах гол зарчмуудыг тогтоож, төсвийн хөрөнгийг ашиглах, хуваарилах, захиран зарцуулах, төсвийн үйл ажиллагааг ил тод байлгах, тайлагнах, төсөвт тавих хяналттай холбогдсон харилцааг зохицуулдаг. Хуулийн зохицуулалт нь дараах хүрээг хамарна:

- Парламентаар хэлэлцүүлэх Засгийн газрын төсвийн төсөл, зардлын төлөвлөгөө болон Засгийн газрын хөрөнгө, өр төлбөрийн хүрээг тогтоож санал боловсруулах;
- Тогтвортой төсвийн удирдлагыг хэрэгжүүлэх зарчим, шалгуурыг тодорхойлох. Төсвийн үйл ажиллагаа нь энэхүү зарчим шалгуурт нийцэж байгаад хяналт тавих боломжийг бий болгох тайлан, мэдээллээр тогтмол хангах;
- Засгийн газар, яамд, парламентын харьяа байгууллагууд болон бусад төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн гаргах санхүүгийн болон санхүүгийн бус тайланг бэлтгэх, эдгээр тайланг холбогдох газруудад хүргүүлэх;

[40] *Public Finance Act 1989, https://www.legislation.govt.nz/act/public/1989/0044/latest/DLM160809.html*

- Зээл авах, хөрөнгө оруулалт хийх, мөнгөн хөрөнгийн зарцуулалт, дериватив, баталгаа, батлан даалт гаргах. Тэдгээртэй холбоотой эрх, үүрэг болон хяналтын 2.Парламентын дэгийн тухай хууль[41]

Парламентын дэгийн тухай хуулийн төсвийн үйл ажиллагаатай холбоотой хэсэг нь дараах харилцааг зохицуулдаг:

- Засгийн газрын төсвийн төслийг хэлэлцэх;
- Засгийн газрын төсвийн гүйцэтгэл болон бусад санхүүгийн үйл ажиллагааны тайланг хэлэлцэх, хяналт тавих;
- Засгийн газраас санхүүгийн хориг тавих.

3.Төрийн аудитын хууль[42]

Төрийн аудитын тухай хууль нь төсвийн болон төрийн өмч хөрөнгө зүй зохистой ашиглагдаж, захиран зарцуулагдаж буй эсэхэд үнэлэлт, дүгнэлт өгөх зорилгоор хийгдэх аудитын үйл ажиллагаатай холбогдох харилцааг зохицуулдаг. Төрийн аудитын гол зорилго парламентаас төсвийн хэрэгжилт, төрийн санхүүд хяналт тавих үүргийг биелүүлэхэд шаардлагатай мэдээллээр хангаж, зөвлөх явдал юм.

Төсөв, санхүүгийн мэдээллийн систем

Төсвийн санхүүгийн мэдээллийн системийн зорилго нь төсвийн гүйцэтгэлийн хяналтыг тавихад шаардлагатай мэдээллээр Засгийн газар, парламент, Аудитын газар болон олон нийтийг хангахад оршино. Найдвартай бодит мэдээллээр хангагдсанаар төсвийн хөрөнгийн зарцуулалтыг зөв үнэлж, хяналт тавих боломжтой болдог. Төсвийн санхүүгийн мэдээллийн систем нь ил тод, шилэн, хүртээмжтэй байх зарчимд тулгуурласан байдаг.

Төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хийхдээ нь цахим технологид суурилсан CFISnet (Crown Financial Information System буюу Төрийн санхүүгийн мэдээллийн систем) мэдээллийн системийг ашигладаг[43]. Энэ системийг Сангийн яам удирдан зохион байгуулдаг. Төсвийн гүйцэтгэлийн хяналтыг Засгийн газрын гаргасан төсвийн гүйцэтгэлийн тайлан дээр үндэслэн хийнэ.

Зураг 4.Төсвийн гүйцэтгэл, хяналтын тайлан



[41] *Standing Orders of the House of Representatives, 2023, https://www.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders/*
[42] *Public Audit Act 2001, https://www.legislation.govt.nz/act/public/2001/0010/latest/DLM88541.html*
[43] *Putting It Together An Explanatory Guide to New Zealand's State Sector Financial Management System, https://www.treasury.govt.nz/publications/guide/putting-it-together-explanatory-guide-new-zealands-state-sector-financial-management-system#putting-it-together*

Засгийн газрын нэгдсэн санхүүгийн тайлан: Засгийн газраас гаргаж буй тайланг CFISnet системийн мэдээллийг ашиглан Сангийн яам бэлтгэнэ. Засгийн газрын тайлан дараах 3 хэлбэртэй байна:

1. Төсвийн жилийн дундуурх тайлан (жилийн турш тогтмол). Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг сараар, улирлаар гарган парламент, Аудитын газарт хүргүүлэн, олон нийтэд хүртээмжтэй байхаар түгээнэ.
2. Хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайлан. Хагас жилийн эдийн засгийн шинэчилсэн үнэлгээ, төсвийн тодотголын баримт бичгийн хамт Санхүү, зарлагын байнгын хороонд хүргүүлж, байнгын хороод, парламентын хуралдаанаар хэлэлцүүлнэ.
3. Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан. Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан нь Төсвийн гүйцэтгэлд хяналт тавих гол баримт бичиг болдог. Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэн Санхүү, зарлагын хороо, бусад байнгын хороод, парламентын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

Санхүү, зарлагын байнгын хороо болон бусад байнгын хороодын тайлан: Сангийн сайд Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг парламентаар хэлэлцүүлэхээр Санхүү, зарлагын байнгын хороонд хүргүүлдэг. Санхүү, зарлагын хороо нэгдсэн тайланг хянан хэлэлцээд, шинжилж тайлан боловсруулна. Мөн түүнчлэн холбогдох яамдын төсвийн гүйцэтгэлийг бусад байнгын хороонд хуваарилна. Бусад байнгын хороод нь хамаарах яамдын төсвийг хэлэлцэн шинжилж тайлан боловсруулна. Санхүү, зарлагын болон бусад байнгын хороодын тайланг, Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлангийн хамт парламентын хэлэлцүүлэгт оруулна.

Аудитын тайлан: Ерөнхий Аудитор, хянагчийн газар нь Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан болон яамд, газар нэгжүүдийн төсвийн гүйцэтгэлийг хянан бие даасан Аудитын тайлан бэлтгэж парламентад өргөн барьж хэлэлцүүлдэг.

Төсвийн гүйцэтгэлийн хяналт

Төсвийн гүйцэтгэлийн хяналт 3 төрөлтэй байна.

Хүснэгт 10.Төсвийн гүйцэтгэлийн хяналтын төрөл

Төсвийн гүйцэтгэлийн хяналтын төрөл	Оролцогч талууд	Тайлан
Засгийн газрын дотоод хяналт	Сангийн яам, Сайдын дэргэдэх бие даасан хянагч зөвлөх	Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайлан
Парламентын хяналт	Санхүү, зарлагын хороо, бусад байнгын хороод	Санхүү зарлагын байнгын хороо болон бусад байнгын хороодын тайлан
Аудитын хяналт	Ерөнхий Аудитор, хянагчийн газар	Аудитын тайлан

Засгийн газрын дотоод хяналт: Засгийн газрын дотоод хяналт нь Сангийн яамны хяналт ба яамдын дотоод хяналт гэсэн 2 төрөлтэй.

1. Сангийн яамнаас тавих хяналт. Засгийн газрын төсвийн хяналтыг Сангийн яам гүйцэтгэнэ. Төсвийн захирагчид нь төсвийн захиран зарцуулалттай холбоотой мэдээллийг тухай бүрд нь (real-time) CFISnet системд оруулах бөгөөд Сангийн яам энэ системээр дамжуулан төсвийн зарцуулалтын хяналтыг шууд тавих боломжтой байдаг. Яам, агентлагууд төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр Сангийн яаманд хүргэх бөгөөд Сангийн яам төсвийн хөрөнгө зориулалтын дагуу, төсөвлөгдсөн хөрөнгийн хүрээнд зарцуулагдсан эсэхэд хяналт тавина.
2. Яамдын дотоод хяналт. Яамдын сайдууд нь дэргэдээ бие даасан хяналтын зөвлөх ажиллуулна. Хяналтын зөвлөх нь тухайн яамны ажилтан, гаднын зөвлөх эсвэл Сангийн яамны тусгай ажилтан байж болно. Хяналтын зөвлөх нь Төсвийн хөрөнгийн зарцуулалтын үр ашиг, төсвийн хөрөнгөөр худалдан авч буй бараа үйлчилгээний өртөг, үйл ажиллагааны зардлын үнэлгээний талаар бие даасан үнэлэлт өгч зөвлөдөг.

Парламентын хяналт[44]: Санхүү, зарлагын байнгын хороо нь Засгийн газрын төсвийн гүйцэтгэлд хяналт тавина. Сангийн сайдаас жилийн эцсийн тайланг Санхүү, зарлагын байнгын хороонд хүргүүлэн, хэлэлцүүлж хянуулна. Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн тайлан дараах мэдээллийг агуулна:

- Санхүүгийн үйл ажиллагааны тайлан;
- Нийт орлогын тайлан;
- Санхүүгийн тэнцэл;
- Мөнгөн урсгалын тайлан;
- Зээл, өр төлбөрийн тайлан;
- Зарлагын задаргааны шинжилгээ;
- Үнэ цэнгийн үнэлгээний тайлан;
- Төлөвлөгдөөгүй зарлагын тайлан;
- Гэнэтийн болзошгүй зарлагын тайлан.

Парламентаас төсвийн гүйцэтгэлд хяналт тавихад дараах дэгийг баримтална:

- Тухайн парламентын бүрэн эрх хэрэгжиж эхлэхэд Санхүү, зарлагын хорооноос аль байгын хороо аль яамдын төсвийн зарцуулалтыг хянаж байхыг тогтоон хуваарилдаг.
- Санхүү, зарлагын байнгын хороо Засгийн газрын санхүүгийн нэгдсэн тайланг хянана.
- Тухайн байнгын хороо нь түүнд харьяалагдах яамд, агентлагийн төсвийн гүйцэтгэлийг жил бүр хянана.
- Төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хийх тухай төлөвлөгөөг тухайн жилийн эхний ажлын өдрөөс хойш долоо хоногийн дотор парламентаар батлуулна.
- Санхүү, зарлагын байнгын хороо болон бусад байнгын хороод нь төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ сайд, төсвийн захирагч нарыг байлцуулж тайлбар авна.

---

[44] *Public Finance Act, Part 3. Reporting by Government reporting entity,* https://www.legislation.govt.nz/act/public/1989/0044/latest/whole.html#DLM162015

- Санхүү, зарлагын байнгын хороо болон байнгын хороод нь 3 сарын 31-ний дотор төсвийн гүйцэтгэлийг хянаж парламентад тайлагнана.
- Парламентын хурлаар төсвийн гүйцэтгэлийн талаар хэлэлцүүлэг явуулна.

Жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлээс гадна Хагас жилийн төсөв, эдийн засгийн тодотголыг парламентаар хэлэлцүүлнэ. Энэхүү баримт бичгийг Санхүү, зарлагын байнгын хороонд хүргүүлж хянуулна. Санхүү, зарлагын байнгын хороо Хагас жилийн төсөв, эдийн засгийн тодотголыг ажлын 40 хоногийн дотор хэлэлцэх ба тайлангаа бэлтгэж парламентаар хэлэлцүүлнэ.

Ерөнхий Аудитор, хянагчийн газраас тавих хяналт: Аудитын хяналтыг Ерөнхий Аудитор, хянагчийн газар (*Controller and General Auditor's Office*) хэрэгжүүлнэ. Энэ нь парламентын харьяа байгууллага бөгөөд Аудитын хяналтыг парламентын хяналтын нэг хэсэг гэж үзнэ. Төрийн аудитыг парламентын харьяа Ерөнхий Аудитор, хянагчийн газар хийх бөгөөд дараах чиглэлээр аудит хийдэг:

- Засгийн газар, төрийн байгууллага, аж ахуйн нэгжийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд аудит хийх;
- Засгийн газар, төрийн байгууллага, аж ахуйн нэгжид гэрээний үндсэн дээр нэмэлт аудит хийх;
- Засгийн газар, төрийн байгууллага, аж ахуйн нэгжид үйл ажиллагааны хийгээд санхүүгийн аудит хийх.

Аудитын хяналтын зорилго нь төсвийн хөрөнгө хуулийн хүрээнд зориулалтын дагуу зарцуулагдаж байгаад хяналт тавьж, парламентыг мэдээллээр хангахад оршино. Ерөнхий Аудитор, хянагчийн газар нь төсвийн гүйцэтгэлийн хяналтын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

- Сангийн яам бүх төрлийн төсвийн зарлагын мэдээллийг сар бүр Ерөнхий Аудитор, хянагчийн газарт хүргүүлнэ.
- Хэрэв Ерөнхий Аудитор, хянагчийн газар нь төсвийн зарцуулалтыг Төсвийн хуульд заасан хүрээнд бус байна гэж үзвэл энэ талаар парламентад тайлагнах шаардлагатайг Сангийн сайд эсвэл тухайн сайдад мэдэгдэнэ.
- Хэрэв төсвийн зарцуулалтыг хууль бус, төсвийн хуулийн хүрээнд биш гэж үзвэл тухайн зарлагыг гаргаж буй төрийн сангийн дансны гүйлгээг зогсоож болно.
- Хэрэв татвар төлөгчдийн мөнгөний зарцуулалт зориулалтын бус бол тухайн мөнгөн хөрөнгийг зарцуулахыг түдгэлзүүлж болно.

3.2 БҮГД НАЙРАМДАХ СЛОВЕНИ УЛС

Бүгд Найрамдах Словени Улс нь Парламентын засаглалтай бүгд найрамдах улс. Хууль тогтоох байгууллага нь Парламент бөгөөд дээд, доод гэсэн хоёр танхимтай. Дээд танхим нь Үндэсний зөвлөл, доод танхим нь Үндэсний Ассамблей байна.

Бүгд Найрамдах Словени Улсад улсын төсвийг хэлэлцэн батлах, түүний гүйцэтгэлийг хянахтай холбоотой Төрийн санхүүгийн тухай хууль, Стратегийн хөгжлийн баримт бичиг, улсын төсвийн төслийг боловсруулах үндэслэл, журмын тухай

тогтоол, Парламентын Дэгийн тухай хууль, Төсвийг хэрэгжүүлэх тухай хууль, Дэгийн тухай хуулийг хэрэгжүүлэх тухай журмаар тус тус зохицуулагдана.

Төсвийн хөрөнгөөр үйл ажиллагааг зохицуулах, хэрэгжилтэд тавих хяналтыг Сангийн асуудал эрхэлсэн яам[45] хэрэгжүүлнэ. Сангийн асуудал эрхэлсэн яам нь төсвийн гүйцэтгэлийн хяналт, дүгнэлт шийдвэрийн талаар Засгийн газар, Аудитын шүүх (Court of Audit)[46] Үндэсний Ассамблей (Парламент)-д хагас жил тутамд тайлагнана[47].

Засгийн газар нь төрийн санхүүгийн бодлого, бүтцийн шинэчлэлийн хэрэгжилтэд хөндлөнгийн үнэлгээ хийлгэх зорилгоор Төсвийн зөвлөлийг байгуулдаг бөгөөд энэ нь төсвийн бие даасан санхүүгийн байгууллага юм. Төсвийн зөвлөлийн гишүүдийг Сангийн асуудал эрхэлсэн сайд санал болгосноор, Засгийн газар томилдог. Төсвийн зөвлөл нь 7 гишүүнээс бүрддэг, бүрэн эрхийн хугацаа 5 жил байх бөгөөд Зөвлөлийн гишүүд нь Төсвийн зөвлөлийн даргыг гишүүд дундаас сонгодог. Засгийн газар болон Парламентад ажлаа тайлагнадаг байна.

Төсвийн гүйцэтгэлийг хянахтай холбоотой хууль эрх зүйн орчин

Бүгд Найрамдах Словени Улсад дараах хууль, эрх зүйн баримт баримт бичгүүд улсын төсвийг хэлэлцэн батлах, түүний гүйцэтгэлийг хянахтай холбоотой асуудлын эрх зүйн орчныг бүрдүүлж байна. Үүнд:

- Төрийн санхүүгийн тухай хууль (*Public Finance Act*);
- Стратегийн хөгжлийн баримт бичиг, улсын төсвийн төслийг боловсруулах үндэслэл, журмын тухай тогтоол (*Decree on Strategic Development Documents and on the Bases and Procedures for Preparation of a Proposed National Budget);*
- Парламентын Дэгийн тухай хууль (*Rules of Procedure of the Parliament*);
- Төсвийг хэрэгжүүлэх тухай хууль (*Implementation Act of the Republic of Slovenia Budget*);
- Дэгийн тухай хуулийг хэрэгжүүлэх тухай журам (*Rules on the procedures of implementing the budget of the Republic of Slovenia).*

Төрийн санхүүгийн тухай хууль нь Бүгд Найрамдах Словени Улсын төсөв болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагуудын төсвийн бүрдэл, бэлтгэл, гүйцэтгэлийн үйл явц, төрийн болон хотын өмчийн хөрөнгө, төрийн болон хотын захиргааны өр, зээлийн удирдлага, улсын санхүүгийн нягтлан бодох бүртгэл, дотоод хяналт, төсвийн хяналттай холбоотой харилцааг зохицуулна[48].

Засгийн газрын хөгжлийн төлөвлөлтийн баримт бичиг, улсын төсөв боловсруулах журам нь хөгжлийн төлөвлөлтийн баримт бичгийг бэлтгэх, хэрэгжүүлэх, хяналт тавих арга, бодлого боловсруулах, үндэсний хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, төсвийн санамж бичиг боловсруулах, улсын төсөв боловсруулах, түүнд

---

[45] *Словенийн Төрийн санхүүгийн тухай хуулийн 102 дугаар зүйл* https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/2011-01-0449/#(Priprava%C2%A0predloga%C2%A0ob%C4%8Dinskega%C2%A0prora%C4%8Duna)

[46] *Republic of Slovenia Court of Audit* https://www.rs-rs.si/en/


[47] *Словенийн Төрийн санхүүгийн тухай хуулийн 106* https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/2011-01-0449/#(Priprava%C2%A0predloga%C2%A0ob%C4%8Dinskega%C2%A0prora%C4%8Duna)

[48] *Za k o n o javnih financah. 1.1.1.* https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/2011-01-0449/#1.%C2%A0%C4%8Dlen

нэмэлт, өөрчлөлт оруулах, тэнцвэржүүлэх журам, баримт бичиг, түүнчлэн эдгээр акттай холбоотой бусад баримт бичгийг боловсруулах асуудлыг зохицуулна[49].

Парламентын Дэгийн хуулиар улсын төсвийг хэлэлцэх, батлах, гүйцэтгэлийг хянах асуудлыг тусгажээ[50]. Тус хууль нь 2002 оны 7 дугаар сарын 15-ны өдрөөс хүчин төгөлдөр хэрэгжиж эхэлсэн байна. Энэ хууль нь нийт 9 удаагийн нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд хамгийн сүүлд 2023 оны 5 дугаар сарын 26-ны өдөр нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна. Парламентын Дэгийн тухай хуулийн 4 дүгээр бүлгийн 3 дахь хэсэгт улсын төсвийг хэлэлцэх, батлах журмыг тогтоожээ. Засгийн газар дараа оны төсвийн төслийг тухайн оны 10 дугаар сарын 1-ний дотор Парламентад өргөн мэдүүлнэ.

Зураг 5.Төрийн санхүүгийн тухай хуульд заасан төсвийг боловсруулах явц



Эх сурвалж:https://www.pempal.org/sites/pempal/files/attachments/3a_volj-_budget-system-and-budget-preparation-procedures-in-slovenia_eng.pdf

Зураг 6.Улсын төсвийн төслийг Парламентаар хэлэлцэн батлах үе шат



Эх сурвалж: Македоны Парламентын хүрээлэн "Төсвийн хяналтад парламентын гүйцэтгэх үүрэг" хамтарсан судалгаа,2019 www.sobranie.mk

---

[49]*Uredba o dokumentih razvojnega načrtovanja in postopkih za pripravo predloga državnega proračuna.1.1.1. http://www.pisrs.si/Pis.web/pregledPredpisa?id=URED5312*

[50]*Rules of Procedure of the Parliament. https://imss.dzrs.si/IMiS/ImisAdmin.nsf/IMiSNetAgent?OpenAgent&2&DZ-MSS01/ecba208564d333f66a6eabfb7c5e9d06ed97e54277741a40748a99c7efa33072*

Үндэсний Ассамблейн дарга төсвийн төсөл өргөн мэдүүлснээс хойш 5 хоногийн дотор төсвийн төсөл, төсвийн санамж бичиг, хуульд заасан төсвийн төсөлтэй холбоотой бусад баримт бичгийг, түүнчлэн төсвийн төслийг танилцуулах чуулганыг зарлан хуралдуулах тухай мэдэгдлийг Үндэсний Ассамблейн гишүүдэд хүргүүлдэг байна. Төсвийн санамж бичиг, төсвийн төслийг танилцуулах чуулганыг төсвийн төслийг өргөн мэдүүлснээс хойш 10 хоногийн дотор Үндэсний Ассамблейн дарга зарлан хуралдуулна.

Үндэсний Ассамблейн чуулганд төсвийн төслийг танилцуулснаас хойш 10 хоногийн дотор төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг депутат, депутатын бүлэг, холбогдох ажлын байгууллагад танилцуулна. Төсвийн орлого, зарлагын тэнцвэрт байдлын тухай дүрмийг бүх нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргагчид анхааралдаа авна. Танилцуулсан нэмэлт, өөрчлөлтүүд нь төсвийн нөөц хөрөнгө, төсвийн ерөнхий үүрэг хариуцлагад хамаарахгүй байх ёстой бөгөөд нэмэлт зээлийн дарамт учруулахгүй байх ёстой.

Төсвийн төслийг Үндэсний Ассамблейн чуулганд өргөн мэдүүлснээс хойш Засгийн газар 30 хоногийн дотор төсөвт оруулсан бүх нэмэлт, өөрчлөлтийн талаар эдийн засгийн чиг хандлага, төсвийн хэрэгжилтийн талаарх сүүлийн үеийн дүн шинжилгээнд үндэслэн байр суууриа илэрхийлж тухайн оны төсвийн тодотголын төслийг боловсруулж, Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ.

Засгийн газар төсвийг нэмэгдүүлэх, зээлийн хэмжээг нэмэгдүүлэх санал гаргаж болно. Төсвийн тодотголын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг хариуцсан Байнгын хороо, дэд хэсэг, эсхүл нийт депутатын дөрөвний нэгээс доошгүй хувийг оруулж ирж болно. Хариуцсан Байнгын хороо нь төсвийн тодотголын төсөл болон өргөн мэдүүлсэн нэмэлт, өөрчлөлтийн талаар байр суууриа илэрхийлж, өөрчлөлтийн талаарх өөрийн байр суурийг тусгасан тайлан боловсруулна.

Төсвийн тодотголын төслийг өргөн мэдүүлснээс хойш 15 хоногийн дараа төсвийн тодотгол хэлэлцэх Үндэсний Ассамблейн чуулганы хуралдааныг хуралдуулна. Засгийн газрын төлөөлөгч өргөн мэдүүлсэн нэмэлт, өөрчлөлтийн талаар тайлбарлаж хийнэ. Дараа нь хариуцсан Байнгын хороо тайлангаа танилцуулна. Үүний дараа намын бүлгийн төлөөлөгчид уг асуудлаар саналаа илэрхийлнэ. Төсвийн тодотголын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн тусгай хэсгийн нэмэлт өөрчлөлт оруулсан зарим зүйлийг хэлэлцэж дууссаны дараа парламент шийдвэр гаргадаг. Төслийн зүйл бүрээр санал хураалт дууссаны дараа Үндэсний Ассамблейн дарга төсвийг орлого, зарлагын хувьд, мөн тус тусад нь тэнцвэржүүлэх шийдвэр гаргана. Төсвийн төслийг тэнцвэржүүлсний дараа Үндэсний Ассамблей санал хураалт явуулж баталдаг байна.[51]

Төсвийн гүйцэтгэлд хяналт хийх байгууллагуудын үүрэг, оролцоо

[51] *Rules of Procedure of the Parliament. Part 3, art 155-168.*

Словенийн Парламентад төсвийн хяналтыг хариуцдаг парламентын гол байгууллага нь Санхүүгийн Байнгын хороо (*Committee on Finance*) ба төсвийн гүйцэтгэлд хяналт шалгалт хийх чиг үүрэгтэй байгууллага нь Төрийн санхүүгийн хяналтын хороо (*Commission for Public Finance Control*) тус тус хэрэгжүүлдэг байна.

Санхүүгийн Байнгын хороо нь макро эдийн засгийн бодлого, бүтцийн шинэчлэлийн зохицуулалт, улсын санхүүгийн орлого, зарлагын тухай, төсвийн тухай, төрийн сан, улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, татвар, гаалийн тогтолцоо, санхүүгийн тогтолцоо, актив хөрөнгө, хөрөнгийн батлан даалт,төр хувийн хэвшлийн түншлэл, санхүүгийн харилцааны ил тод байдал, Төв банкны тогтолцоо, мөнгө угаах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хонжворт тоглоом зохион байгуулах, макро төсвийн дүн шинжилгээ, урьдчилсан таамаглал дэвшүүлэх зэрэг асуудалтай холбоотой хуулийн төсөл, бусад акт, асуудлыг хариуцдаг[52].

Төрийн санхүүгийн хяналтын хороо нь улсын төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлдэг парламентын гол байгууллага бөгөөд Словенийн Тэтгэвэр, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн даатгалын сан, Словенийн Эрүүл мэндийн даатгалын сан, Словенийн Олон нийтийн радио телевиз зэрэг байгууллагын санхүүгийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хууль ёсны байдал, зарцуулалтын зорилго, үр ашигтай байдлын үүднээс санхүүгийн тайлангийн үнэн зөвийг Аудитын шүүхийн дүгнэлтэд үндэслэсэн хянадаг. Мөн тус Хороо нь төрийн сангууд, төрийн өмчит аж ахуйн нэгж, төрийн байгууллагууд, орон нутгийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн төлөвлөгөөний хэрэгжилт, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдалд хяналт тавьж, хийсэн хяналтын талаар Үндэсний Ассамблейд тайлагнаж, шаардлагатай арга хэмжээг санал болгодог байна[53].

Төсвийн гүйцэтгэлийн хяналт

Словени Улсын Сангийн асуудал эрхэлсэн яам нь 07 дугаар сард эхний хагас жилийн төсвийн гүйцэтгэлийн тайланг Засгийн газарт тайлагнана. Засгийн газар нь тайлангаа Үндэсний Ассамблей өргөн мэдүүлнэ. Сангийн асуудал эрхэлсэн яам нь төвлөрсөн төсвийн жилийн санхүүгийн тайлан боловсруулж батлах бөгөөд төрийн захиргааны төвлөрсөн төсвийн хүрээний мэдэгдлийг 03 дугаар сарын 31-ний дотор Аудитын шүүхэд хүргүүлнэ. Аудитын тайлангийн төсөлд Аудитын шүүх, аудитор, засаж залруулах арга хэмжээг санал болгож болно. Засгийн газар тухайн оны 10 дугаар сарын 1-ний дотор Сангийн асуудал эрхэлсэн яамны санал болгосноор, төсвийн жилийн санхүүгийн тайлангийн саналыг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлж, батлах, Аудитын шүүхийн эцсийн дүгнэлт болон засаж залруулах арга хэмжээнүүд болон аудитын зөвлөмжийн татгалзсан тайлбарын хамт хүргүүлж болно.

Төсвийн зарцуулалтад тавих хяналтыг Үндэсний Ассамблейгаас гадна, төрийн байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлох Төрийн аудитын байгууллага гэж байна. Энэ байгууллага нь төсвийн гүйцэтгэл, санхүүгийн хяналт, эдийн засаг,

[52] *https://www.dz-rs.si/wps/portal/ Slovenia of the National Assembly*
[53] *Rules of Procedure of the Parliament.art 39.*

хөрөнгийн ашиглалт, дотоод хяналт, дотоод аудитын тогтолцоо зэрэг хяналт шалгалтын үйл ажиллагааг явуулдаг байна. Мөн төсвийн гүйцэтгэлийн хяналтыг Сангийн яамны Төсвийн хяналтын алба хэрэгжүүлдэг. Тус алба нь Сангийн яаманд ажлаа тайлагнаж, Засгийн газарт дүгнэлт, шийдвэрийг мэдээлнэ. Засгийн газрын тайланг Бүгд Найрамдах Словени Улсын Үндэсний Ассамблей болон Төрийн аудитын байгууллагад хүргүүлнэ. Засгийн газрын Парламентад өргөн мэдүүлсэн улсын төсвийн төслийг Аудитын шүүхийн дүгнэлтийн хамт Төрийн санхүүгийн хяналтын хороо болон Үндэсний Ассамблейн чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 дүгээр сарын 1-ний дотор өргөн мэдүүлж, хэлэлцүүлэн батлуулдаг байна.

3.3 БҮГД НАЙРАМДАХ АРМЕНИ УЛС

Бүгд Найрамдах Армени Улс нь тусгаар тогтгосон, ардчилсан нийгмийн эрх зүйт төр юм. Парламентын засаглалтай бүгд найрамдах улс. Хууль тогтоох эрх мэдлийг Үндэсний Ассамблей (парламент) хэрэгжүүлэх бөгөөд нэг танхимтай. Үндэсний Ассамблей нь гүйцэтгэх засаглалд хяналт тавьж, улсын төсөв батлах, Үндсэн хуульд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Төсвийн гүйцэтгэлийг хянах, хэлэлцэн батлахтай холбоотой хууль эрх зүйн орчин

Бүгд Найрамдах Армени Улсад дараах хууль, эрх зүйн зохицуулалтаар улсын төсвийг хэлэлцэн батлах, түүний гүйцэтгэлийг хянахтай холбоотой асуудлыг тусгасан байна. Үүнд:

- Улсын төсвийн тогтолцооны тухай (*On the RA Budgetary System*) хууль[54];
- Үндэсний Ассамблейн Дэгийн тухай (*Rules of procedure of the National Assembly*)[55] хууль;
- Төрийн сангийн тогтолцооны тухай *(On Treasury System)*[56] хууль.

Улсын төсвийн тогтолцооны тухай хууль нь улсын төсөв болон орон нутгийн төсөв боловсруулах үйл явцад төсвийн төслийг боловсруулах, төсвийн орлого, зарлагын ангилал, нягтлан бодох бүртгэл, тайлагнах, төсвийн хэрэгжилт, гүйцэтгэлийн хяналт, төсвийн тогтолцооны үндсэн журмыг тодорхойлохтой холбоотой харилцааг зохицуулна[57].

Үндэсний Ассамблейн Дэгийн тухай хуулийн 5 дугаар бүлгийн 24 дүгээр бүлэгт төсвийн гүйцэтгэлийг хэрэгжилтэд хяналт тавих, Үндэсний Ассамблейн Хянан шалгахтай холбоотой бусад асуудлыг хэлэлцэх журмыг зохицуулсан байна. Уг хуульд төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэх, өргөн мэдүүлэх, санал хураах, хяналтыг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахтай холбогдсон харилцаа, Үндэсний Ассамблейн үйл ажиллагааг

[54] https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Armenia/16_-RA_Law_on_the_budgetary_system_of_the_Republic_of_Armenia.pdf
[55] http://www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=eng
[56] http://www.parliament.am/law_docs/220801HO211eng.pdf?lang=eng
[57] https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Armenia/16_-RA_Law_on_the_budgetary_system_of_the_Republic_of_Armenia.pdf

хангах, төсвийн зардлын төслийг бүрдүүлэх, улсын төсвийн тодотгол, эдийн засгийн ангиллын зүйл ангиудад хуваарилах, төсөвлөх зэрэг асуудлыг зохицуулна[58].

Төрийн сангийн тогтолцооны тухай хуульд Бүгд Найрамдах Армени Улсын болон хотын санхүүгийн эх үүсвэрийн менежмент, тэдгээрийн хөрөнгийн зардлыг санхүүжилт, улсын болон олон нийтийн төсвийн гүйцэтгэлийг хуульд заасны дагуу төрийн сангийн нэгдсэн данснаас санхүүжүүлсэн зардлыг эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлэх, төсвийн байгууллагын санхүүгийн тайлан гаргах, нэгтгэх, нягтлан бодох бүртгэлийн дүрэм, стандартыг мөрдөх, төлбөрийн урьдчилсан хяналтыг хэрэгжүүлэх, улсын болон орон нутгийн төсвийг тайлангийн гүйцэтгэлийн явцад хяналт тавих, ил тодоор үнэлэх, гадаад болон дотоод өрийг удирдах, олон улсын байгууллагуудтай холбоотой төлбөрийг зохицуулах, хянах зэрэг асуудлуудыг тусгажээ. Төрийн сан нь Засгийн газрын эрх бүхий төрийн сангийн төв байгууллага болон орон нутгийн төрийн сангаас бүрдэнэ[59].

Үндэсний Ассамблейн дэгийн тухай хууль нь 2016 оны 12 дугаар сарын 16-ны өдөр батлагдсан бөгөөд 34 бүлэг 167 зүйл ангитай. “Дэгийн тухай” хуульд 2017-2023 онуудад нийт 7 удаа нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. “Дэгийн тухай” хуулийн 5 дугаар бүлгийн 24 дүгээр зүйлд төсвийн гүйцэтгэлд хяналт тавих асуудлыг тусгажээ. Үндэсний Ассамблейн хэвийн үйл ажиллагааг хангах асуудлыг Үндэсний Ассамблейн дарга хариуцдаг байна.

Улсын төсвийг "Бүгд Найрамдах Армени Улсын төсвийн тогтолцооны тухай" хуульд заасан дагуу Ерөнхий сайдын захирамжаар төсвийн хүрээний мэдэгдлийг төсвийн төсөлд тусгах асуудлыг Үндэсний Ассамблей бэлтгэж, Засгийн газарт хүргүүлнэ. Төсвийн хүрээний мэдэгдлийг Засгийн газар нэмэлт, өөрчлөлтгүйгээр баталж, төсвийн төсөлд тодотголтойгоор тусгана. Засгийн газар төсвийн төсөл, төсвийн төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах үндэслэлийг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ.

Үндэсний Ассамблейн дарга нь шаардлагатай гэсэн тохиолдолд хуулийн дагуу төсвийн зардлыг эдийн засгийн ангиллын зүйл ангиудад нийт хөрөнгийн 15 хувиас хэтрүүлэхгүйгээр дотоодод дахин хуваарилалт хийж зохицуулна.

Засгийн газар нь *төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг* 40 хоногийн дотор төсөв болон зээл, буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн биелэлтийн явцын талаарх Үндэсний Ассамблейд танилцуулдаг. Үндэсний Ассамблей нь төсвийн гүйцэтгэл болон гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, зээлийн зарцуулалтад хяналт тавина. Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн гүйцэтгэлийн төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцдэг байна[60].

---

[58] http://www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=eng
[59] http://www.parliament.am/law_docs/220801HO211eng.pdf?lang=eng
[60] *Rules of procedure of the National Assembly,2022 Art 115*

Аудитын танхимын дүгнэлтийг танилцуулах болон хэлэлцэх асуудлыг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ. Байнгын хороо нь Аудитын танхимын дүгнэлтийн талаар аудитын даргын өгсөн мэдээллийг хянан шалгана. Хороо нь судалгааны үр дүнгээр хороодын хуралдаан эсхүл хороодын хамтарсан хуралдааныг зарлан хуралдуулахаар шийдвэрлэж болно.

Төсвийн гүйцэтгэлийг өргөн мэдүүлэх, хэлэлцэх үед дараах нөхцөлүүдтэй байна:

- Засгийн газар төсвийн гүйцэтгэлийг Төв банкнаас Засгийн газарт өргөн мэдүүлэн хэлэлцсэний дараа жилийн 5 дугаар сарын 1-ний дотор Үндэсний Ассамблейд цахим хэлбэрээр өргөн мэдүүлнэ.
- Төсвийн гүйцэтгэлийг Аудитын танхимын дүгнэлттэй хамт, чуулган дуусахаас өмнө Үндэсний Ассамблейн хуралдаанаар хэлэлцэж, санал хураалт явуулна.
- Аудитын танхим нь 1 сарын дотор төсвийн гүйцэтгэлийг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлнэ.

"Бүгд Найрамдах Армени Улсын төсвийн тогтолцооны тухай" хууль, “Үндэсний Ассамблейн Дэгийн тухай” хуульд заасны дагуу улсын төсвийн төслийг 90-с доошгүй хоногийн дотор, намрын ээлжит чуулганаас хэтрэхгүй хугацаанд Үндэсний Ассамблейн хуралдаанаар хэлэлцүүлдэг байна[61].

Үндэсний Ассамблейн чуулганы хуралдаанаар төсвийн төслийг журмын дагуу хэлэлцэхдээ төслийн эцсийн найруулга, нэгтгэсэн жагсаалтад оруулсан саналыг Ерөнхий сайд, эсхүл Засгийн газраас эрх олгосон төрийн захиргааны байгууллагын дарга нар 1 цагийн хугацаанд үг хэлж, танилцуулах бөгөөд асуулт асуух эрхтэй байна. Хэрэв үг хэлэх хүсэлт гаргасан бол 10 минутын хугацаанд үг хэлэх эрхийг Үндэсний Ассамблейн депутатууд, фракцуудын төлөөлөгч, Байнгын хороодын гишүүд, Үндэсний Ассамблейн дарга, түүний орлогч дарга нарт олгодог байна.

Ерөнхий сайд, төрийн байгууллагын төлөөлөл үг хэлсний дараа улсын төсвийн төслийн эцсийн найруулгыг батална. Хэрэв төсвийн төсөл батлагдаагүй тохиолдолд Засгийн газар санал хураалт явуулснаас хойш 2 долоо хоногийн дотор улсын төсвийн төслийг Үндэсний Ассамблейд өргөн мэдүүлж, 1 сарын дотор хэлэлцэн, санал хураалт явуулна[62].

Засгийн газрын өргөн мэдүүлсэн улсын төсвийн гүйцэтгэлийн явцын мэдээллийг эрх бүхий Байнгын Хорооны хуралдаанаар хэлэлцэнэ. Аудитын танхимын дүгнэлтийг хуульд заасан хугацаанд Парламентад өргөн мэдүүлнэ. Парламентын эрх бүхий байнгын хороо нь Аудитын танхимын дүгнэлтийн талаар аудитын даргын өгсөн мэдээллийг хянан шалгана. Хороо нь судалгааны үр дүнгээр хороодын хуралдаан эсхүл бүсийн хороодын хамтарсан хуралдааныг зарлан хуралдуулахаар шийдвэрлэж болно. Улсын төсвийн гүйцэтгэлийн жилийн тайланг Аудитын танхимын дүгнэлттэй,

[61] *Rules of procedure of the National Assembly, Art 87*
[62] *http://www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=eng*

ээлжит чуулган дуусахаас өмнө Парламентаар хэлэлцэж, санал хураалт явуулах бөгөөд 1 сарын дараа дүгнэлтийг Парламентад өргөн мэдүүлнэ.

Төсвийн гүйцэтгэлд хяналт хийх байгууллагуудын үүрэг, оролцоо

Парламентаар төсөв хэлэлцэх, батлах асуудлыг хариуцдаг эрх бүхий Байнгын хороо болон Төсвийн албатай байна. Үндсэн хуулийн 111 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг болон 20 дугаар бүлгийн 114-118 дугаар зүйлд Үндэсний Ассамблейн хяналт шалгалтыг хэрэгжүүлэх зорилгоор Төсвийн албыг байгуулдаг. Төсвийн алба нь бие даасан байна[63]. Дэгийн тухай хуульд зааснаар Үндэсний Ассамблейн депутатууд, Байнгын хороо, бүлгийн гишүүдэд мэргэжлийн туслалцаа, үйл ажиллагаа, мэдээллээр хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ. Төсвийн албаны үйл ажиллагааг хяналтын эрх бүхий Байнгын хороо хэрэгжүүлдэг.

Парламент нь Зөвлөлтэй байна. Зөвлөлд Парламентын дарга, түүний гурван орлогч, бүлгийн нэг төлөөлөгч, Байнгын хорооны дарга нараас бүрдэнэ. Зөвлөл нь хуралдааны дэг, өөрийн тогтоолоор батлагдсан журмын дагуу ажиллана. Зөвлөлийн хуралдаан нээлттэй байна. Зөвлөл нь төсөвтэй холбоотой дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Төсвийн албаны ажиллах журам, шинжээч томилох хугацаа, сонгууль (томилгоо) явуулах журам, шинжээч томилох журмыг эрх бүхий байнгын хорооны саналаар батлах, төсвийн мэргэжилтнүүдийн сахилгын бүртгэлийг хэлэлцэх;
- улсын төсвийн төслийг урьдчилсан хэлэлцүүлэгт бэлтгэх, байнгын хороод болон хамтарсан хуралдаанаараа санал оруулах, Засгийн газар нэмэлт, өөрчлөлт оруулах хуваарийг батлах;
- жилийн төсвийн тайланг байнгын хороодоор хэлэлцүүлэх урьдчилсан хэлэлцүүлгийн хуваарийг батлах зэрэг асуудлуудыг хамруулсан байна.

[63] http://www.parliament.am/budget_office.php?sel=about&action=legal&lang=eng

Ашигласан эх сурвалж

1. Global Parliamentary Report, 2017 https://www.undp.org/publications/global-parliamentary-report-2017
2. The role of the Parliament in the Budget scrutiny process, 2019 https://www.sobranie.mk/content/%D0%9F%D0%B0%D1%80%D0%BB%D0%B0%D0%BC%D0%B5%D0%BD%D1%82%D0%B0%D1%80%D0%B5%D0%BD%20%D0%B8%D0%BD%D1%81%D1%82%D0%B8%D1%82%D1%83%D1%82/Billateral%20research%20Macedonia%20and%20Czechia%2012,19.pdf
3. Төсвийн Тухай Мэдээлэл 20240808-2 (1).pdf ТТБЗ, Төсвийн тухай мэдээлэл.2024.08.12, х11
4. Армени Улсын Парламентын дэгийн тухай хуулийн 5 бүлэг, 24.2 дэх зүйл
5. Шинэ Зеландын төсвийн хяналт https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/new-zealand
6. Армени Улсын төсвийн хяналт https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/armenia
7. Монгол Улсын төсвийн хяналт https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/mongolia
8. Шинэ Зеландын төсвийн хяналт https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/new-zealand
9. Словени Улсын төсвийн хяналт https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/slovenia
10. МУ:ОУВС-гийн МУ-ыг хариуцсан мэргэжилтнүүдийн байр суурь (mongolia-mcs-2024-mon (2).pdf).
11. УИХ-ын хяналт шалгалтын тухай хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140615614031
12. Budgeting and Public Expenditures in OECD Countries 2019,page 82 https://www.oecd-ilibrary.org/docserver/9789264307957-en.pdf?expires=1730710839&id=id&accname=guest&checksum=8043FBB98CEADF7109DDB4EB08912D86
13. Budgeting and Public Expenditures in OCED Countries, 2019, page 84
14. Монгол Улсын Үндсэн хууль https://legalinfo.mn/mn/detail?lawId=367
15. УИХ-ын тухай хууль, 2024 https://legalinfo.mn/mn/detail?lawId=17140610916031
16. УИХ-ын хяналт шалгалтын тухай хуулийн 4,5,21 дүгээр зүйл
17. Төрийн аудитын тухай хуулийн 6, 7 дугаар зүйл
18. Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйл
19. New Zealand The Treasury, https://www.treasury.govt.nz/publications/guide/putting-it-together-explanatory-guide-new-zealands-state-sector-financial-management-system#planning-and-budgeting
20. New Zealand, Standing orders 2023, Chapter 6.Financial procedures, https://www.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders-2023-by-chapter/chapter-6-financial-procedures/
21. New Zealand Public Finance Act 1989, https://www.legislation.govt.nz/act/public/1989/0044/latest/DLM160809.html
22. New Zealand Standing Orders of the House of Representatives, 2023, https://www.parliament.nz/en/pb/parliamentary-rules/standing-orders/
23. New Zealand, Public Audit Act 2001, https://www.legislation.govt.nz/act/public/2001/0010/latest/DLM88541.html
24. Putting It Together An Explanatory Guide to New Zealand's State Sector Financial Management System, https://www.treasury.govt.nz/publications/guide/putting-it-together-explanatory-guide-new-zealands-state-sector-financial-management-system#putting-it-together
25. New Zealand, Public Finance Act, Part 3. Reporting by Government reporting entity, https://www.legislation.govt.nz/act/public/1989/0044/latest/whole.html#DLM162015
26. Словенийн Төрийн санхүүгийн тухай хуулийн 102,106 дугаар зүйл https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/2011-01-0449/#(Priprava%C2%A0predloga%C2%A0ob%C4%8Dinskega%C2%A0prora%C4%8Duna)
27. Republic of Slovenia Court of Audit https://www.rs-rs.si/en/
28. Slovenia, Za k o n o javnih financah. 1.1.1. https://www.uradni-list.si/glasilo-uradni-list-rs/vsebina/2011-01-0449/#1.%C2%A0%C4%8Dlen
29. Slovenia. Uredba o dokumentih razvojnega načrtovanja in postopkih za pripravo predloga državnega proračuna.1.1.1. http://www.pisrs.si/Pis.web/pregledPredpisa?id=URED5312
30. Rules of Procedure of the Parliament,Slovenia https://imss.dzrs.si/IMiS/ImisAdmin.nsf/IMiSNetAgent?OpenAgent&2&DZ-MSS01/ecba208564d333f66a6eabfb7c5e9d06ed97e54277741a40748a99c7efa33072

31. Rules of Procedure of the Parliament. Part 3, art 155-168.
32. Slovenia of the National Assembly https://www.dz-rs.si/wps/portal/
33. Rules of Procedure of the Parliament, Slovenia. art 39
34. law of the republic of Armenia on the budgetary system of the republic of Armenia https://track.unodc.org/uploads/documents/BRI-legal-resources/Armenia/16_-RA_Law_on_the_budgetary_system_of_the_Republic_of_Armenia.pdf
35. RULES OF PROCEDURE OF THE NATIONAL ASSEMBLY http://www.parliament.am/parliament.php?id=bylaw&lang=eng
36. TREASURY SYSTEM LAW http://www.parliament.am/law_docs/220801HO211eng.pdf?lang=eng
37. Armenia http://www.parliament.am/budget_office.php?sel=about&action=legal&lang=eng
38. Армени Улсын Парламентын дэгийн тухай хуулийн 5 бүлэг, 24-2 https://internationalbudget.org/open-budget-survey/country-results/2023/armenia
39. УИХТГ-ын ПСХ-ийн “Парламентын төсөв санхүүгийн хяналт, олон улсын туршлага” харьцуулсан судалгаа
40. Public finance and budgets https://www.oecd.org/gov/budgeting/Parliament-role-in-budgeting.pdf
41. Budgeting and Public Expenditures in OECD Countries 2019. page 82 https://www.oecd-ilibrary.org/docserver/9789264307957-en.pdf?expires=1730710839&id=id&accname=guest&checksum=8043FBB98CEADF7109DDB4EB08912D86
42. Objectives of Budgetary Control https://www.shiksha.com/online-courses/articles/budgetary-control-steps-objectives-and-advantages/
43. Common principles of budgetary control https://online.sunderland.ac.uk/what-is-budget-control/
44. Steps in the Budgetary Control Process https://www.shiksha.com/online-courses/articles/budgetary-control-steps-objectives-and-advantages/
45. Төсвийн хяналтын давуу талууд https://www.shiksha.com/online-courses/articles/budgetary-control-steps-objectives-and-advantages/
46. ЕХ гишүүн орнуудын аудитын дээд байгууллага https://op.europa.eu/webpub/eca/book-state-audit/en/
47. OECD Best Practices for Parliaments in Budgeting.2023 https://www.pbo.gov.au/sites/default/files/2023-05/OECD%20Best%20Practices%20for%20Parliaments%20in%20Budgeting%20Jan%202023.pdf
48. Budgetary control https://www.procuredesk.com/glossary/budgetary-control/#:~:text=It%20refers%20to%20the%20process,the%20company's%20objectives%20are%20met.